

Үр дүнтэй нийгмийн халамжийн системийн чадавхи бэхжүүлэх нь

АХБ ТТ 9893-МОН

**Зорилтот өрхийн хөгжил, хамгаалал үндэсний
хөтөлбөрийн үнэлгээ (ЗӨХХҮХ)**

Цогтсайханы Болормаа, Бямбаагийн Энхцэцэг

2021 оны 3-р сар

Өмнөх үг

Үнэлгээний ажлыг олон байгууллага, хамт олон, хувь хүний дэмжлэгтэйгээр гүйцэтгэсэн. Үнэлгээг хийхэд үнэтэй санал зөвлөмж өгч, хамтран ажилласан, тусалсан дараах байгууллага, хамт олон, хувь хүмүүст судалгааны багийн хамт олныхоо өмнөөс “ТАЛАРХАЛ” илэрхийлж байна. Үүнд:

- ОПМ төслийн хамт олон – ялангуяа, зөвлөх Махам Фархатад үнэлгээний ажлыг хийхэд удирдлага, зохицуулалтаар хангаж, үнэтэй санал зөвлөмж өгсөнд;
- ХНХЯ-ны хамт олон – ялангуяа, Нийгмийн хамгааллын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Нийгмийн халамжийн хэлтсийн дарга М. Цогтбаатар, Бодлого, төлөвлөлтийн газрын Нийгмийн хамгааллын хэлтсийн ахлах шинжээч нарт үнэлгээний ажлыг гүйцэтгэхэд санал зөвлөмж өгч, холбогдох мэдээллээр ханган, хамтран ажилласанд,
- ХХҮЕГ-ын хамт олон – ялангуяа, хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн Б.Нэргүйд хөтөлбөрийн талаарх тоо мэдээллээр хангаж, чанарын судалгааны мэдээлэл цуглуулахад тусалж, ярилцлаганд оролцогчидтой холбогдоход тусалсанд;
- ХАССТ-ийн судалгааны багийн хамт олон – ялангуяа, төслийн дэд ахлагч док.Б.Энхцэцэгт үнэлгээг хийхэд удирдлага, зохицуулалтаар хангаж, зөвлөн тусалсанд, мөн судлаач док. Т.Сүмжидмаад орон нутгаас чанарын мэдээлэл цуглуулах, ярилцлага хийхэд хамтран ажилласанд;
- Улаанбаатар хотын Сонгинохайрхан, Налайх дүүргийн ХХҮГ-ийн мэргэжилтнүүд, Хөвсгөл аймгийн ХХҮГ-ын хамт олон, мэргэжилтнүүд Мөрөн болон Хатгал сумын холбогдох байгууллага, хувь хүмүүст орон нутагт үнэлгээний ажлыг зохион байгуулж, мэдээлэл цуглуулахад үнэтэй хувь нэмэр оруулж, тусалсанд;
- Мөн чанарын судалгааны ярилцлаганд оролцсон бүх ганцаарчилсан оролцогчиддоо хөтөлбөрийн талаарх өөрсдийн туршлага, сургамжаа хуваалцаж, үнэтэй мэдээлэл өгсөнд гүн талархал илэрхийлье.

Хураангуй

Энэхүү тайлан нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас хэрэгжүүлсэн Зорилтот өрхийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөрийн үнэлгээг танилцуулж байна.

Хөтөлбөр өрхийн амьжиргааны түвшин болон амьжиргаагаа дээшлүүлэх чадавхид үндэслэн орон нутгийн нийгмийн халамжийн байгууллагуудаар сонгогдсон 55,000 (жил бүр 13,500) өрхийг хамруулсан.

Энэ үнэлгээний гол зорилго бол Зорилтот өрхийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөрийн ач холбогдол, үр дүнг үнэлэх явдал байв. Мөн үнэлгээ нь ХНХЯ-нд үндэсний хөтөлбөрийг цаашид үргэлжлүүлэх эсэхийг шийдвэрлэхэд дэмжлэг болох төдийгүй хөтөлбөрийн загвар, хэрэгжилтийг сайжруулах арга замын талаар санал боловсруулах зорилготой. Цаашилбал, уг үнэлгээний үр дүнг нийгмийн халамжийн шинэчилсэн хуулийг эцэслэн боловсруулахад ашиглах юм.

Үнэлгээ нь төв, орон нутгийн удирдлага, аймаг/дүүргийн мэргэжилтэн, сум/хороодын ажилтан, үйлчилгээ үзүүлэгчид, өрхүүдийг хамруулсан 70 хагас-стандартчилагдсан ярилцлаганд үндэслэн хийгдсэн. Асуудал харицсан төв байгууллагуудтай хийсэн ярилцлагаас гадна Улаанбаатар хотын 2 дүүрэг (Сонгинохайрхан, Налайх), нэг аймаг (Хөвсгөл)-т мэдээлэл цуглуулах ажлыг зохион байгуулсан. Аймгийн төвийн сумаас гадна хөдөөгийн нэг сумыг үнэлгээнд хамруулсан. Үнэлгээний явцад цуглуулсан мэдээлэл нь тухайн хөтөлбөрийн үйл явцыг бүхэлд нь үнэлж чадахуйц төлөөлөлтэй байж чадахгүй гэдгийг энд сануулмаар байна. Энд танилцуулж буй үр дүн бол зөвхөн үнэлгээний явцад хамрагдсан оролцогчдын хүрээнд цуглуулагдсан мэдээлэл юм.

ЗӨХХҮХ-т 2016-2019 онд нийт 63,349 өрх хамрагдсан байна. Энэ хугацаанд 18,056 зорилтот өрхийн хувьд ахиц дэвшилтэй буюу нийт хамрагдсан өрхийн 28.5 хувь нь өрхийн хөгжилдээ ахиц гаргажээ.

Хэдийгээр ЗӨХХҮХ нь зорилтоо бүрэн биелүүлээгүй ч зарим онуудад ахиц дэвшилтэй байна: 2016 онд сонгогдсон өрхийн 22.2 хувь, 2017 онд 24.5 хувь, 2018 онд 25.8 хувь, 2019 онд 41.6 хувь нь тус тус өрхийн хөгжилдөө ахиц гаргасан байна.

ЗӨХХҮХ нь зорилтот өрхтэй ажиллахад тохиромжтой, цогц хөтөлбөр гэж үнэлгээнд оролцогчид үзсэн байна. Өрхийн хөгжлийн төлөвлөгөө бол хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах гол арга хэрэгсэл байсан ч практикт төдийлэн хэрэглэгдээгүй байна.

Хөтөлбөрт хамрагдсан өрхүүдийн дийлэнх нь өрхийн хөгжлийн гурвалжин (үр шим хүртэгчдийн үнэлгээ)-гийн арга зүйг мэдэхгүй байна. Нийгмийн ажилтнууд сонгогдсон өрхийн хүмүүсийг мэдэгдэж буй үйлчилгээнүүд болон сургалтанд хамруулж, тэдний оролцоог бүртгэдэг аж. Хэрвээ өрх 2-3 үйлчилгээнд хамрагдсан бол тэдний тайланд үндэслэн “амьжиргаа дээшилсэн” гэж үздэг байна.

Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт орон даяар нэлээд ялгаатай байна гэж гол мэдээлэгчид үзэж байна. Учир нь хөтөлбөрийн хэрэгжилт оролцогч талуудын идэвх оролцоо, хандлага, санхүүжилт, орон нутгийн санаачлагаас ихээхэн хамаардаг. Нийгмийн ажилтан сонгогдсон

өрхийн эрэлт хэрэгцээг тусгасан өрхийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулахад тусалж, түүний ахиц дэвшлийг тогтмол хянаж, үнэлж байх ёстой. Гол мэдээлэгчдийн тэмдэглэснээр, нийгмийн ажилтнууд ажлын цаг хүрэлцэхгүй, ачаалал хэт өндөр, ойр ойрхон солигддог, сургалтанд хангалттай хамрагдаж чадаагүй, тэднийг урамшуулах хөшүүрэг сул байдаг аж.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд ямар нэгэн батлагдсан төсөв байхгүй, сонгогдсон өрхийн амьжиргааг ямар нэгэн санхүүжилтгүйгээр нэмэгдүүлнэ гэдэг нь бодитой бус, хэрэгжүүлэх боломжгүй байна. Нийгмийн ажилтнууд дэмжлэг үзүүлэх өрхөө тодорхойлчихоод, тэднийг мэдэгдэж буй үйлчилгээнүүд рүү чиглүүлэн оролцуулж байна. Үүнээс өөр нэмэлт ямар нэг үйлчилгээ алга байна.

Хэдийгээр энэ үнэлгээ үр нөлөөг үнэлэх зорилготой биш ч судалгааны үр дүнгээр, хөтөлбөрийн үр нөлөө нэлээд холимог, тухайлбал, идэвхтэй өрхүүдийн хувьд хөтөлбөр ихээхэн үр дүнтэй, харин идэвх муутай өрхүүдийн тухайд үйлчилгээ болоод сургалтын үр нөлөө бага байсныг харуулж байна. Энэ нь нэг талаас үндэсний хөтөлбөр потенциал үр нөлөөтэй байсан гэдгийг харуулж буй хэрэг юм.

Энэхүү тайлангийн ерөнхий үр дүн бол дэлхийн хэмжээнд хэрэглэгдэж байгаа ижил төстэй хөтөлбөрүүдийн хэрэгжилтээс сургамжуудыг батлах нотлох явдал байсан. ТББ-ын хэрэгжүүлсэн Төгсөлтийн аргачлал хөтөлбөр сайн хэрэгжсэн. Учир нь орон нутгийн түвшний хүний нөөцөөр сайн хангагдсан, маш сайн боловсруулагдсан сургалтын хөтөлбөртэй, эргэлтийн хөрөнгө хуваарилсан, тухайлбал, мал эсхүл бизнес эрхлэх зээл гэх мэт. Нөгөө талаас, ийм аргаар засгийн газрын хөтөлбөрийг хэрэгжүүлнэ гэвэл олон салбар дундын зохицуулалтыг хийхэд хүндрэлтэй, нийгмийн ажилтнууд үргэлжид цаг хугацааны хувьд хязгаарлагдмал байдаг зэрэг нь нөлөөлж болзошгүй. Дэлхийн хэмжээнд хэрэгжсэн төгсөлтийн аргачлалаас сургамж авахад, засгийн газрын түвшинд ийм төрлийн хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэхдээ сайн бодож тунгаах хэрэгтэй байна.

Үнэлгээний үр дүнд үндэслэн дараах гол зөвлөмжүүдийг дэвшүүлж байна. Үүнд:

- Өрхийн амьжиргааны түвшинг дээшлүүлэх, тэдний зан үйлийг өөрчлөх урт хугацаанд хэрэгжүүлэх арга зүйд анхаарах;
- Өрхийг зөв сонгох, тодорхойлохын тулд өрхийн амьжиргааны түвшинг илэрхийлэх үнэлгээ бүхий мэдээллийн санг бий болгох;
- Бодитой, шүүмжлэлтэйгээр нөөцийн үнэлгээг төгсөлтийн хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд хийх;
- Хөтөлбөрийн зорилго, ухуулга сурталчилгааны тухай харилцаа холбоог бий болгох;
- Хөтөлбөрийн загвар, хэрэгжилтийн хамтын аргачлалтай болох;
- Төгсөлтийн аргачлалыг, ялангуяа, түүний тулгуур багана, шалгуур, үр өгөөжийг сайтар судалж, үндэсний хөтөлбөрийн арга зүйтэй уялдуулах.

Агуулга

Өмнөх үг	2
Хураангуй	3
Хүснэгт, зураг, шигтгээний жагсаалт	6
Товчилсон үг	7
1 Удиртгал	8
1.1 Үндэслэл	8
1.2 ЗӨХХҮХ-ийн тухай	8
1.3 Үнэлгээний зорилго	12
1.4 Тайлангийн бүтэц	12
2 Үнэлгээний загвар	13
2.1 Үнэлгээний гол асуултууд	13
2.2 Үнэлгээний арга зүй	14
3 Үнэлгээний үр дүн	16
3.1 Хөтөлбөрийн ач холбогдол	17
3.2 Хөтөлбөрийн үр дүн	19
3.3 Хөтөлбөрийн тогтвортой байдал	24
4 Хэлэлцүүлэг	27
4.1 Дүгнэлт	27
4.2 Зөвлөмж	28
Ашигласан материал	30
Хавсралт А Гол мэдээлэгчийн жагсаалт	31
Хавсралт Б Нэмэлт мэдээлэл	33

Хүснэгт, зургийн жагсаалт

Хүснэгт 1: Өрхийн хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлсэн өрх, хүн амын тоо, 2016-2019	11
Хүснэгт 2: Судалгаанд оролцогчдын тоо	14
Хүснэгт 3: Институцийн түвшин дэх боломж, бэрхшээлүүд	22
Хүснэгт 4: Өрхийн түвшин дэх боломж, бэрхшээлүүд	23
Хүснэгт 5: ЗӨХХҮХ болон Төгсөлтийн аргачлал хоорондын харьцуулалт, зарим сонгосон үзүүлэлтээр	24
Зураг 1: ЗӨХХҮХ-ийн үйл ажиллагааны хүрээ	9
Зураг 2: Өрхийн хөгжлийн гурвалжин	10
Зураг 3: ЗӨХХҮХ-т хамрагдсан өрхийн тоо, ахиц дэвшил гарсан өрхийн хувийн жин (2016-19 оны эцсийн байдлаар)	17

Товчилсон үг

АХБ	Азийн хөгжлийн банк
ГМЯ	Гол мэдээлэгчийн ярилцлага
ЗӨХХСҮХ	Зорилтот өрхийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр
МУИС	Монгол улсын их сургууль
ОПМ	Оксфорд полиси менежмент
ӨНЭЗС	Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа
ТХЗ-ууд	Тогтвортой хөгжлийн зорилтууд
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ХАССТ	Хүн амын сургалт, судалгааны төв
ХБХ	Хөгжлийн бэрхшээлтэй хүн
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ХХҮЕГ	Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар
ХХҮГ	Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар

1 Удиртгал

1.1 Үндэслэл

Монголын макро эдийн засгийн байдал сүүлийн жилүүдэд тогтворгүй байна. Эдийн засгийн өсөлт 2019 онд 5.2 хувьд хүрч, 2016 онтой харьцуулахад 4.0 пунктээр, өмнөх жилтэй харьцуулахад 2.0 пунктээр буурчээ. Үндэсний статистикийн хороо (ҮСХ)-ны¹ Өрхийн нийгэм-эдийн засгийн судалгааны дүнгээр, үндэсний ядуурлын түвшин 2018 онд 28.4 хувь байна. Ядуурлын түвшин 2016 оны түвшинтэй харьцуулахад 1.2 пунктээр буурсан байна. Ядуурлын хамралтын өөрчлөлтийг бүсээр харвал, Зүүн бүсэд ядуурлын түвшин 43.9 хувиас 37.4 хувь, Баруун бүсэд 36.0 хувиас 31.8 хувь, Хангайн бүсэд 33.6 хувиас 30.8 хувь, Төвийн бүсэд 26.8 хувиас 26.1 хувь бол тус тус буурчээ. Харин нийслэл Улаанбаатар хотын хувьд ядуурлын түвшин 24.8 хувиас 25.9 хувь болж нэмэгдсэн байна. Ийнхүү ядуурлын түвшин буурсан ч нийт хүн амын бараг гуравны нэг нь ядуу хэвээр байна. Ядуурал хүмүүсийн амьдралд олон талаараа нөлөөлж байна. Бага орлоготой өрхүүдийн амьдралд эдийн засгийн хүндрэл шууд болон бус замаар нөлөөлж, ихээхэн сорилтуудыг бий болгож байна.

Зорилтот өрхийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр (2016-2020) 2016 онд Засгийн газрын 16 дугаар тогтоолоор батлагдсан. Тус хөтөлбөр нь өрхийн амьжиргааг дээшлүүлэхийн тулд өрхийн хэрэгцээнд үндэслэн боловсрол, эрүүл мэнд, халамж, хөдөлмөр эрхлэлт, санхүүгийн үйлчилгээг багцлан зохион байгуулалттайгаар хүргэх зорилготой төдийгүй ТХЗ-уудад хүрэх нэг хариу үйлдэл юм.

ЗӨХХҮХ нь 2020 онд хэрэгжээд дууссан. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (ХНХЯ) болон Хөдөлмөр, халамжи үйлчилгээний ерөнхий газраас уг хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлж, цаашид хөтөлбөрийг хэрэгжүүлэх эсэхэд зөвлөмж гаргаж өгөхийг Азийн хөгжлийн банкны техникийн тусламжийн багаас хүссэн.

1.2 ЗӨХХҮХ-ийн тухай

Өрхийн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр 2012-2015-ийн хүрээнд Өрхийн хөгжлийн төлөвлөгөө нь нийгмийн тусламж, дэмжлэг хэрэгтэй өрх, хүн амд нийгмийн багц үйлчилгээг хүргэх, тэдний сөрөг зан үйл, дадлыг өөрчлөх зорилготой байсан. Энэхүү багц үйлчилгээ нь 6 чиглэлд: боловсрол, эрүүл мэнд, сэтгэл зүй, нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт, санхүүгийн зэрэг байв.

Хөтөлбөрт 55,000 өрх хамрагдаж, тэдгээрийн бараг 30-иас дээш хувийнх нь амьжиргааны түвшин дээшилсэн талаар хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланд дурьджээ².


Дээр дурьдсан үндэсний хөтөлбөрийн туршлагад үндэслэн 2016 онд Монгол Улсын Засгийн газрын 16 дугаар тогтоолоор “Зорилтот өрхийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр 2016-2020”-ыг баталсан байна. Тус **хөтөлбөр нь өрхийн амьжиргааг дээшлүүлэхийн тулд өрхийн хэрэгцээнд үндэслэн боловсрол, эрүүл мэнд, халамж, хөдөлмөр эрхлэлт, санхүүгийн үйлчилгээг багцлан зохион байгуулалттайгаар хүргэх**

¹ ҮСХ, www.1212.mn

² ХХҮЕГ, 2014. Өрхийн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан

зорилготой. Үндэсний хөтөлбөрийн үйл ажиллагааны ерөнхий хүрээг Зураг 1-д дүрслэн харуулав.

Зураг 1: ЗӨХХҮХ-ийн үйл ажиллагааны хүрээ



Эх сурвалж: Хөтөлбөрийн баримт бичгийг үндэслэн зохиогч боловсруулав.

Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн тулд арга зүйн чиглэлийн дараах баримт бичиг, удирдамж заавар, маягыг Сайдын тушаалаар баталжээ. Үүнд:


- Зорилтот өрхийн хөгжлийн үнэлгээний аргачлал
- Зорилтот өрхийн хөгжлийн төлөвлөгөөний загвар
- Зорилтот өрхийн хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх зөвлөмж
- Зорилтот өрхийн хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн маягт
- Зорилтот өрхийн хөгжлийн ахиц дэвшлийн маягт
- Зорилтот өрхийн хөгжлийн төлөвлөгөөний биелэлтийн нэгтгэл тайлан
- Зорилтот өрхийн хөгжлийн ахиц дэвшлийн нэгтгэл
- Зорилтот өрхийн хөгжлийн төлөвлөгөөний үр дүнгийн мониторингийн маягт
- Аймаг, дүүргийн хэмжээнд хөтөлбөрт хамруулах өрхийн тооны доод хязгаар

Зорилтот өрхийн хөгжил хамгааллын үндэсний хөтөлбөрийн хувьд өрхийн мэдээллийн нэгдсэн сангийн 409-с доош буюу нийгмийн халамжийн тусламж дэмжлэг зайлшгүй шаардлагатай өрхөөс хамруулдаг бөгөөд Амьжиргааг дэмжих зөвлөлөөр зөвшөөрөгдөн дэмжигдсэн байх ёстой. Эдгээр шалгуураас гадна гар аргаар болон жижиг бичил уурхайд ажиллагсад³, шоронгоос суллагсад, гэр бүлийн хүчирхийллийн хохирогч, архины хамааралтай иргэн, шилжигчид, хүнд нөхцөлд байгаа хүүхдүүд, орон гэргүй хүмүүс мөн энэхүү хөтөлбөрт хамрагдах боломжтой.

³ Бүлэг хүмүүс, ялангуяа, эмзэг байдал, доройтолд өртсөн бүлэг.

Сонгогдсон өрхийн суурь үнэлгээг жил бүрийн 7 сарын нэгний дотор 3 түвшин, 7 бүлэг, 14 асуудлын 38 үзүүлэлт бүхий “Өрхийн хөгжлийн гурвалжин”-ы (Зураг 2-ыг хар) тусламжтайгаар хийгдэнэ. Батлагдсан аргачлалаар бол жил бүрийн 6 дугаар сарын 20-оос 7 сарын 1-ний дотор өрхийн суурь үнэлгээг нийгмийн халамжийн ажилтан өрхтэй хамтран хийх ёстой.

Зураг 2: Өрхийн хөгжлийн гурвалжин



Зорилтот өрхийн хөгжлийн гурвалжин⁴ нь өрхийн үнэлгээнд ашиглагдах бөгөөд өрхийн хөгжлийн эрэлт хэрэгцээний гурван түвшинг илэрхийлнэ. Нэгдүгээр түвшин нь өрхийн “Үндсэн хэрэгцээ” болох орон байр, хоол хүнс, хэрэглээ, санхүү, ажил эрхлэлтийг, хоёрдугаар түвшин нь өрх, өрхийн гишүүдийн “Чадавхи, боломж”-ийг буюу тухайн өрх үндсэн хэрэгцээгээ хангахад шаардлагатай чадавхи, боломж бий эсэхийг тодорхойлно. Гуравдугаар түвшин нь “Ёс суртахуун, хүндлэл” буюу тухайн өрхийн нийгэмд эзлэх байр суурь, гэр бүлийн үнэ цэнэ, нийгмийн харилцаа, оролцоо гэсэн талыг илэрхийлнэ.

Нийгмийн ажилтан нь гурвалжингаар өрхийн үнэлгээг хийхээс гадна Өрхийн нэгдсэн мэдээллийн сангаас сонгогдсон өрхийн талаарх нэмэлт мэдээллийг авна. Үнэлгээг хийх үеэр нийгмийн ажилтнууд бүгд сургалтад хамрагдаж, өрхийн үнэлгээг хэрхэн хийх, өрхийн хөгжлийн зорилго, зорилтыг тодорхойлох, хөгжлийн төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх, хянах үнэлэх арга зүйд суралцах ёстой. Сургалтын ХХҮЕГ-аас зохион байгуулдаг.

Үнэлгээний дүнд үндэслэн өрхийн хэрэгцээний түвшин болон өрхийн гишүүн бүрт шаардлагатай анхаарал халамжийг тодотгосон өрхийн хөгжлийн түвшин тодорхойлогдоно⁵. Өрхийн гишүүн бүр хөгжлийн түвшинг сайжруулахад хүчин чармайлт гаргаж, боломж, давуу талаа ашиглах, зан үйлээ эерэг арга замаар өөрчлөхөд бэлэн байж, идэвхтэй оролцох ёстой.

“Өрхийн хөгжлийн төлөвлөгөө” нь хөтөлбөрийн хэрэгжүүлэхэд ашиглагдсан үндсэн арга хэрэгсэл юм. Энэхүү төлөвлөгөө бол өрхийн нөхцөл байдал, хэрэгцээ шаардлага, нөөц, чадавхид үндэслэн өрхийн амьжиргааны түвшинг дээшлүүлж, хөгжүүлэх зорилготой үйл явц. Төлөвлөгөөг хэрэгжүүлснээр өрхийн гишүүд өөрсдийнхөө төлөө амьдрах, ажиллах,

⁴ Based on [Maslow's Hierarchy of Needs](#) theory

⁵ Суурь үнэлгээгээр өрх 60 ба түүнээс доош оноотой бол “Заавал хөгжих өрх”, хэрэв 61-80 оноо авсан бол “Хөгжлийн төлөөх өрх”, 81-90 оноотой бол “Хөгжлийг дэмжигч өрх”, 91-100 оноо авсан бол “Хөгжлийг бүтээгч” өрх гэж нэрлэгдэнэ.

амьжиргаагаа дээшлүүлэх, гэр бүлийн харилцаагаа сайжруулах, нийгмийн оролцоогоо нэмэгдүүлэх, нийгэмд эзлэх байр сууриа бэхжүүлэх хүсэл эрмэлзэлтэй болно.

“Зорилтот өрхийн хөгжлийн төлөвлөгөө”-г сонгогдсон өрхүүд сум, хорооныхоо нийгмийн ажилтантай хамтран боловсруулан, хэрэгжүүлдэг. Нийгмийн ажилтан нь өрхийн болон өрхийн гишүүдийн нөхцөл байдлыг тодорхойлж, үнэлэх, өрхийн зорилго, зорилт, түүнд хүрэх арга замыг тодорхойлох, төлөвлөгдсөн үйл ажиллагаануудыг хэрэгжүүлэхэд тэдэнд тусалдаг. Мөн түүнчлэн, нийгмийн ажилтан нь өрх нэг бүртэй уулзаж, нийгмийн үйлчилгээ, орон нутгийн болон бусад салбар байгууллагуудтай хамтарсан үйл ажиллагаа, тэдгээрийн талаарх мэдээллийг өрхүүдэд хүргэж, холбогдох байгууллагуудтай холбон хамтран ажилладаг.

Өрхийн хөгжлийн төлөвлөгөө нь дараах бүрэлдэхүүн хэсгүүдтэй. Үүнд:

- Өрхийн хөгжлийн зорилго (өрхийн 3-5 жилийн хугацааны хөгжлийн зорилго, хүрэхийг тэмүүлж буй ахиц дэвшил), зорилт (дунд хугацаа буюу 1-2 жилд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны дүнд гарах үр дагавар буюу үр нөлөө)
- Өрхийн хөгжлийн төлөвлөгөө буюу төлөвлөлт
- Өрхийн хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилт
- Өрхийн хөгжлийн төлөвлөгөөний үйл явцад өрхийн гишүүдийн оролцоо, идэвх санаачлага
- Өрхийн хөгжил, ахиц дэвшлийн төлөөх хамтын ажиллагаа, нээлттэй, уян хатан бодлого, хөтөлбөрүүд

Өрхийн хөгжилд гарсан өөрчлөлтийг жил бүр суурь үнэлгээний аргаар үнэлж, ахиц дэвшлийг маш энгийнээр “Ахиц дэвшил гарсан”, “Өөрчлөлтгүй”, “Хөгжлийн түвшин буурсан” хэмээн тодорхойлж, бүлэглэнэ. Мөн өрх бүрт танилцуулж, дараагийн төлөвлөгөө, үйл ажиллагаанд ашиглана.

Өрхийн хөгжлийн төлөвлөгөөг 2016-2019 онд хэрэгжүүлсэн өрх, хүн амын тоог Хүснэгт 1-д харуулав. Хөтөлбөр хэрэгжих хугацаанд нийт 63,349 өрхийн 289,314 хүн ам өрхийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлжээ. ХХҮЕГ-ын тайлангаас харахад, 2016-2019 онд 18,056 өрхийн амьжиргаа ямар нэг байдлаар дээшилж, өрхийн хөгжлийн түвшинд ахиц дэвшил гарчээ. Энэ нь хөгжлийн төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлсэн нийт өрхийн 28.5 хувийг эзэлж байна гэж ХХҮЕГ-ийн тайланд тэмдэглэжээ⁶.

Хүснэгт 1: Өрхийн хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлсэн өрх, хүн амын тоо, 2016-2019

Он	Өрхийн тоо	Хүн амын тоо	Ахиц дэвшил гарсан өрхийн тоо
2016	13,600	64,200	3,032
2017	17,409	76,744	4,212
2018	16,800	75,254	4,342
2019	15,540	73,116	6,470
Total	63,349	289,314	18,056

Эх сурвалж: ХХҮЕГ, 2016-2019. ЗӨХХҮХ-ийн хэрэгжилтийн жилийн тайлан

Ерөнхийдөө, өрхийн хөгжилд ахиц дэвшил гарсан эсэхийг үнэлэхдээ, 14 бүлгийн 38 үзүүлэлтийн 3-4 үзүүлэлтэд өөрчлөлт орж, сайжирсан бол “өөрчлөлт” гарсан гэж үздэг. Өнгөрсөн хугацаанд Үндэсний хөтөлбөрийн хяналт-шинжилгээ үнэлгээний ажил бараг

⁶ ХХҮЕГ, 2016-2019. Зорилтот өрхийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн жилийн тайлан

хийгдээгүй, жил бүрийн эцэст хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн өгөгдсөн маягтын дагуу тайлан гаргадаг байна⁷.

Тус үндэсний хөтөлбөрийн 2016-2019 оны хэрэгжилтийн тайланд үр дүнгийн дараах шалгуур үзүүлэлтийн зорилтот түвшиндээ хүрч чадаагүйг дурьджээ. Үүнд:

- Зорилтот өрхийн ажилгүй иргэдийн 50-иас илүү хувь нь байнгын ажлын байртай болсон байх;
- Өрхийн хөгжлийн төлөвлөгөөнд хамрагдсан өрхийн 50-иас илүү хувь нь хөгжлийн түвшингээ дээшлүүлсэн байх;
- Өрхийн хөгжилд ахиц дэвшил гарсан өрхүүдийн 30 хувь нь ядуурлаас гарсан байх.

1.3 Үнэлгээний зорилго

Энэ үнэлгээний гол зорилго бол Зорилтот өрхийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөрийн ач холбогдол, үр дүнг үнэлэх явдал байв. Мөн үнэлгээ нь ХНХЯ-нд үндэсний хөтөлбөрийг цаашид үргэлжлүүлэх эсэхийг шийдвэрлэхэд дэмжлэг болох төдийгүй хөтөлбөрийн загвар, хэрэгжилтийг сайжруулах арга замын талаар санал боловсруулах зорилготой. Цаашилбал, уг үнэлгээний үр дүнг нийгмийн халамжийн шинэчилсэн хуулийг эцэслэн боловсруулахад ашиглах, үнэлгээнээс гарах зөвлөмжүүдийг үндэсний болон олон улсын түвшинд хэрэгжсэн ижил төстэй, тухайлбал, төгсөлтийн аргачлал гэх мэт хөтөлбөрүүдийн туршлага, сургамжинд үндэслэн боловсруулсан.

1.4 Тайлангийн бүтэц

Бүлэг 1-д үнэлгээг хийх үндэслэл, зорилго, ЗӨХХСҮХ-ийн тухай товч мэдээллийг өгнө. **Бүлэг 2**-т үнэлгээнд ашиглагдсан судалгааны ерөнхий загварын талаар буюу хариулт авахыг хүссэн гол асуултууд, чанарын судалгааны арга зүй: мэдээлэл цуглуулалтын арга хэрэгсэл, мэдээлэл цуглуулалтын тухай танилцуулна. **Бүлэг 3** үнэлгээний гол үр дүн, тайлбар дүгнэлтийг нэгтгэн өгүүлэх болно. Эцэст нь, ерөнхий дүгнэлт болоод үнэлгээний дүнд үндэслэн боловсруулсан бодлогын зөвлөмжийг танилцуулна (**Бүлэг 4**). Нэмэлт хүснэгтүүд, гол мэдээлэгчийн ярилцлаганд оролцогчдын жагсаалт, үнэлгээний асуулгын хуудсыг тайлангийн төгсгөлд хавсаргасан болно.

⁷ Гол мэдээлэгчийн ярилцлага

2 Үнэлгээний загвар

2.1 Үнэлгээний гол асуултууд

Үнэлгээ гурван гол асуудалд анхаарсан. Үүнд: хөтөлбөрийн ач холбогдол, үр дүн, тогтвортой байдал. Цаг хугацаа болоод нөөцийн хязгаарлагдмал байдлаас шалтгаалан хөтөлбөрийн үр нөлөө буюу үр өгөөжийг үнэлэх боломжгүй байв.

Үнэлгээний зорилгыг хангахын тулд дараах асуултуудад хариулт авахыг хүссэн. Үүнд:

Хөтөлбөрийн ач холбогдол:

- a. Монгол Улсын нийгмийн халамжийн тогтолцоонд хөтөлбөрийн гүйцэтгэж буй үүрэг роль юу вэ?
- b. Үндэсний хэмжээний бодлогын зорилтуудтай хөтөлбөр хэрхэн уялдан холбогддог вэ?
- c. Үндэсний хэмжээний бусад хөтөлбөр, үйлчилгээнүүдийн эцсийн үр дүнд хөтөлбөр ямар хувь нэмэр оруулж байгаа вэ?

Хөтөлбөрийн үр дүн:

- a. Хөтөлбөр анхнаасаа зорилго, зорилтоо хангах түвшинд боловсруулагдаж чадсан уу?
 - i. “Өрхийн хөгжлийн гурвалжин” арга зүйг ашиглан өрхийн хэрэгцээний түвшинг тодорхойлоход хэр үр дүнтэй байна вэ?
 - ii. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд нийгмийн халамжийн ажилтнуудыг ажиллуулах нь хэр үр дүнтэй байдаг вэ?
- b. Хөтөлбөр өөрийн зорилго, зорилтоо биелүүлж чадаж байна уу? Тийм бол, яаж? Үгүй бол, яагаад?
- c. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад тохиолдсон хамгийн гол гол сорилтууд юу вэ? Эдгээр сорилт хөтөлбөрийн зорилго/зорилтын биелэлтэд яаж нөлөөлсөн бэ?
- d. Дээр дурьдсан сорилтуудыг даван туулахад ХНХЯ болон ХХҮЕГ-аас ямар арга хэмжээ авсан бэ?
- e. Хөтөлбөрийг хэрэгжүүлснээс хойш одоог хүртэлх хугацаанд ямар гол гол ололт амжилттай байсан бэ??
 - i. Үндэсний хөтөлбөрийн үр нөлөө юу байна вэ?
 - ii. Хүргэгдэж буй үйлчилгээнүүд болоод тэдгээр нь хоорондоо харилцан уялдаатай ажилладаг уу?
- f. Хөтөлбөрийн хүрээнд хүргэж байгаа үйлчилгээнүүдийн талаар зорилтот өрхүүд ямар бодолтой байдаг вэ? Тэд үүнд сэтгэл ханамжтай байдаг уу?
- g. Энэ хөтөлбөрийн хүрээнд хамрагдах ёстой бусад өрх, хүн ам байна уу?

Хөтөлбөрийн тогтвортой байдал:

- a. Хөтөлбөр хэрхэн санхүүждэг вэ? Дунд хугацаанд санхүүжилт цаашид үргэлжлэх боломжтой юу?
- b. Хөтөлбөрийн үр шим хүртэгчдэд үзүүлж буй ямар ажиглагдсан үр нөлөө байна уу? Мөн ирээдүйд нийгмийн халамжийн тогтолцоонд ямархуу нөлөө үзүүлж болохоор байна вэ?

- c. ХНХЯ хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах явцдаа ямар сургамж олж авсан бэ? Ирээдүйд хэрэгжих ижил төстэй хөтөлбөрүүдэд энэхүү сургамжтай байдлыг анхааран үздэг үү?
- d. Энэхүү хөтөлбөрийг цаашид үргэжлүүлэн хэрэгжүүлэх ямар нэг сонирхол бодлого боловсруулагч, хэрэгжилтийг ханган ажилладаг ажилтнууд болоод үр шим хүртэгчдийн хувьд байгаа юу? Тийм бол, хөтөлбөрийн чанар, ач холбогдол, хэрэглээг сайжруулахын тулд ямар санал өгч байна вэ? Үгүй бол, яагаад?

2.2 Үнэлгээний арга зүй

Үнэлгээг баримт бичгийн шинжилгээ, хоёрдогч мэдээллийн дүн шинжилгээ, чанарын мэдээлэл цуглуулах зэрэг холимог аргачлалын хүрээнд хийсэн. Холимог аргачлал нь тайлбарлах шинж чанар бүхий энэ төрлийн судалгааны ажилд хамгийн тохиромжтой байдаг. Дөрвөн зорилтот бүлэг (яам, орон нутгийн удирдлагын ажилтнууд, нийслэл, аймгийн түвшний мэргэжилтнүүд, Хамтарсан баг болон Амьжиргааг дэмжих зөвлөлийн гишүүдийн төлөөлөл, үр шим хүртэгчид)-ээс дэлгэрэнгүй мэдээллийг цуглуулж, судалгааны гол асуултуудад хариулахыг оролдсон.

Чанарын мэдээлэл цуглуулалтыг Хөвсгөл аймаг болон Улаанбаатар хотод 2020 оны 11 сарын эхнээс 12 сарын төгсгөл хүртэлх гурван долоон хоногийн хугацаанд явуулсан. Судалгаанд Хөвсгөл аймгаас 2 сум (Мөрөн, Хатгал) сонгогдсон. Улаанбаатар хотын 9 дүүргээс 2 дүүрэг (Сонгинохайрхан, Налайх) сонгогдон судалгаанд хамрагдсан. Сонгогдсон дүүрэг тус бүрээс 2 хороо сонгосон. Тэдгээр хорооны нэг нь хөтөлбөр хэрэгжилтийн сайн туршлага, нөгөө нь сургамж болох гэсэн шалгуурын хүрээнд сонгогдсон болно. Мэдээлэл цуглуулах явцад аль болох олон оролцогчдоос тэдний дуу хоолойг сонсож, дэлгэрэнгүй мэдээлэл авахыг зорьсон. Сум, хорооны ажилтнууд ярилцлаганд оролцогчид (үр шим хүртэгчид)-ыг олж өгөхөд тусалсан.

Гол мэдээлэгчийн 70 ярилцлага, тухайлбал, яам, агентлаг болон нийслэл, аймгийн удирдах ажилтнуудын 14, нийслэл, аймаг, сумын мэргэжилтнүүдийн 10, Хамтарсан баг, Амьжиргаа дэмжих зөвлөлийн гишүүдийн төлөөллийн 10, хорооны ажилтнуудын 8, үр шим хүртэгчдийн 28 ярилцлагыг тус тус зохион байгуулан, мэдээлэл авсан. Гэхдээ мэдээлэл цуглуулалт нь үйл ажиллагааны үр дүнгийн төлөөллийг бүхэлд нь судлахаар загварчлагдаагүй тул дүгнэлт нь зөвхөн төлөөлөл төдий юм.

Гол мэдээлэгчдийн талаарх нэгтгэлийг Хүснэгт 2-д харуулав.

Хүснэгт 2: Судалгаанд оролцогчдын тоо

Аймаг/нийслэл	Зорилтот бүлэг	Оролцогчдын тоо
Улаанбаатар	Яам, агентлагийн удирдах ажилтан	5
Улаанбаатар	Дүүрэг, хорооны удирдах ажилтан	5
Хөвсгөл	Аймаг, сумын удирдах ажилтан	4
ДЭД ДҮН		14
Улаанбаатар	Дүүргийн мэргэжилтэн	4
Хөвсгөл	Аймаг, сумын мэргэжилтэн	6
ДЭД ДҮН		10
Улаанбаатар	Амьжиргааг дэмжих зөвлөл, Хамтарсан багийн гишүүн	6
Хөвсгөл	Амьжиргааг дэмжих зөвлөл, Хамтарсан багийн гишүүн	4
ДЭД ДҮН		10

Аймаг/нийслэл	Зорилтот бүлэг	Оролцогчдын тоо
Улаанбаатар	Хорооны ажилтнууд	8
ДЭД ДҮН		8
Улаанбаатар	Үр шим хүртэгчид	18
Хөвсгөл	Үр шим хүртэгчид	10
ДЭД ДҮН		28
НИЙТ ДҮН		70

Аймаг, сумын болон дүүргийн засаг дарга нараас ярилцлага авахаар төлөвлөсөн байсан ч 2020 оны 10 дугаар сард болсон орон нутгийн сонгуулийн улмаас тэдний зарим нь солигдон, шинэчлэгдсэн тул судалгаанд оролцуулаагүй.

Гол мэдээлэгчийн ярилцлага дунджаар 1-1.5 цаг үргэлжилж, оролцогчийн ажлын байр эсвэл гэрт нь зохион байгуулагдсан. Ярилцлагыг хагас стандартчилагдсан асуулгын хуудсын тусламжтайгаар явуулсан.

Мэдээлэл цуглуулах ажил маш богино хугацаанд хийгдэр шаардлагатай байсныг энд цохон тэмдэглэмээр байна. Мэдээлэл цуглуулалт 3 долоо хоногт, мэдээлэл боловсруулалт, дүн шинжилгээ, тайлан бичих үйл явц 4 долоо хоног үргэлжилсэн. Мөн Хөвсгөл аймагт гол мэдээлэгч нэг бүртэй биечлэн уулзаж мэдээлэл цугуулсан бол Улаанбаатар хотод КОВИД-19-ий хоригийн улмаас утсаар ярилцлага хийж, мэдээлэл цуглуулсан болно.

3 Үнэлгээний үр дүн

Энд хоёрдогч мэдээллийн дүн шинжилгээ болон чанарын судалгааны гол үр дүнг судалгааны гол асуултуудын хүрээнд танилцуулна. Оролцогчдын өгсөн дэлгэрэнгүй мэдээллийг тайланд налуу хэлбэрээр бичиж, хэлсэн үгийг бүтнээр эсвэл ишлэл болгон тодорхой хэсгийг оруулсан.

ЗӨХХҮХ нь 4 жилийн хугацаанд 55,000 орчим өрхөд дэмжлэг үзүүлэх зорилготой (жил бүр 13,500 өрх). Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2016 оны 2 дугаар сарын 22-ны өдрийн А/26 дугаар тушаалаар хөтөлбөрт хамрагдах өрхийн тооны доод хязгаарыг⁸ баталсан байдаг (Хавсралтад харуулав). Аймаг, дүүргээс сонгогдох өрхийн хэмжээг тухайн аймаг/дүүргийн хүн амын Монгол Улсын нийт хүн амд эзлэх хувийн жинтэй пропорционалиар тогтоосон. Үүний дараагаар, аймаг/дүүргийн нийт квотын хэмжээг сум, хорооны хүн амын тоонд пропорционалиар дахин хуваарилаж сум/хороодоос сонгогдох өрхийн тоог гаргасан ба хороодын хувьд өрхийн тоог тэнцвэртэйгээр хуваарилсан байна. Хэрвээ өрх тухайн жилд сонгогдчихвол дараагийн жилүүдэд дахин сонгогдохгүй.

Хөвсгөл аймаг бусад аймагтай харьцуулахад өрхийн сонголтыг өөрөөр хийсэн учраас сонгогдсон өрхийн тоо жил бүр ялгаатай байв (Зураг 3). Хөвсгөл аймгийн хувьд 4 жилийн хугацаанд 2,845 өрхийн квоттой байсан бөгөөд өрхийн хөгжлийн зорилго (өрхийн ойрын ирээдүйн /3-5 жил/ хүсэл тэмүүлэл), зорилт (ойрын хугацаа /1-2 жил/-нд өрхийн хэрэгжүүлэх үйл ажиллагаанууд)-д үндэслэн 2,845 өрхийг бүгдийг нь хөтөлбөр хэрэгжүүлж эхэлсэн эхний жилээс сонгон хамруулсан байна. Үндэсний хөтөлбөрийн тогтоосон квот нэг жилийн хувьд хэт их, нийгмийн ажилтнууд маш их ачаалалтай ажилладаг учраас ахиц дэвшил гарахад их хүндрэлтэй⁹. Тийм учраас, 2018 онд хөтөлбөрт хамрагдах өрхийн тоог 2 дахин багасгаж, 1,218 өрхийг сонгон 2018 оноос 2 жилийн хугацаанд хөтөлбөрт хамруулжээ.

Хөвсгөл аймгаас бусад аймаг, дүүргийн хувьд нэг жилд хөтөлбөрт хамруулах доод хязгаарын тоогоор өрхүүдийг хөтөлбөрт хамруулсан¹⁰. Тухайлбал, Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүрэг жил бүр 1,000 гаруй өрх (2017 онд 1,008 өрх, 2018 онд 1,012 өрх, 2019 онд 1,010 өрх)-ийг шинээр сонгон, хөтөлбөрт хамруулж, өрхийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулан ажиллажээ. Тэдгээр зорилтот өрхөөс 2018 онд 135 өрх, 2019 онд 160 өрх Дэлхийн Зөнгийн төсөл (ө.х. төгсөлтийн аргачлалын төсөл)-д давхар хамрагдсан байна¹¹. Харин Улаанбаатар хотын Налайх дүүрэгт 2016-2019 онд жил бүр 123 өрх хөтөлбөрт хамрагджээ.

Хэдийгээр ЗӨХХҮХ нь тавьсан зорилгодоо хүрч чадаагүй ч өрхүүдийн хувьд жилээс жилд ахиц дэвшил гарсан байна. Зураг 3-т 2016-2019 онд үндэсний хөтөлбөрт хамрагдсан нийт өрхийн тоо мэдээллийг харуулав. Зургаас харахад, 2016 онд 13,600 өрх хөтөлбөрт хамрагдаж эдгээр өрхийн 22.2 хувь нь өрхийн хөгжлийн түвшингээ дээшлүүлсэн бол энэ хувь 2017 онд 24.5 хувь, 2018 онд 25.8 хувь байжээ. Харин 2019 онд 15,540 өрх хамрагдаж эдгээр

⁸ Хөтөлбөрт хамрагдах өрхийн тооны доод хязгаарыг баталж өгсөн. Тийм учраас, жил бүр сонгогдох өрхийн тоо ижил байх албагүй гэсэн үг.


⁹ Гол мэдээлэгчийн ярилцлага

¹⁰ Гол мэдээлэгчийн ярилцлага

¹¹ Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн Хөдөлмөр, халамжийн хэлтсийн жилийн ажлын тайлан 2017-2019.

өрхийн 6,470 буюу 41.6 хувь нь өрхийн хөгжлийн түвшингээ дээшлүүлж чадсан байна. Энэ нь хөтөлбөрийн хэрэгжилт сүүлийн жилд мэдэгдэхүйц ахицтай байсныг харуулж байна.

Зураг 3: ЗӨХХҮХ-т хамрагдсан өрхийн тоо, ахиц дэвшил гарсан өрхийн хувийн жин (2016-19 оны эцсийн байдлаар)



Үндэсний хөтөлбөрт хамрагдсан өрхүүд мөн Дэлхийн зөнгийн төсөлд давхар хамрагдсанаар 2019 онд өрхийн хөгжлийн түвшинд ихээхэн ахиц гаргажээ: Үндэсний хөтөлбөрт 2019 онд 15,540 зорилтот өрх хамрагдсаны 5,567 өрх буюу 35.8 хувь нь Улаанбаатараас, үлдсэн 9,973 өрх 64.2 хувь нь аймаг, орон нутгаас сонгогдсон байна. Дэлхийн зөн 2018-2019 онд 10 аймгийн 115 сум, 4 дүүрэгт зорилтот бүлэг, иргэдийг хамруулсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлсэн. Уг төсөл нь 3,600 гаруй өрхийг хамруулж, өрхийн орлогыг нэмэгдүүлэх үүднээс 841 хүнийг талх, нарийн боовны болон оёдлын сургалтад сургаж, 110 өрхөд тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлсэн байна¹².

3.1 Хөтөлбөрийн ач холбогдол

ЗӨХХҮХ нь зорилтот өрхтэй тулж ажилладаг цорын ганц цогц хөтөлбөр гэж дийлэнх оролцогчид үзэж байна. Судалгаанд хамрагдагчдын дийлэнх олонх нь, ялангуяа, яам/агентлагийн удирдах ажилтнууд, аймаг/дүүргийн мэргэжилтнүүд ихээхэн эерэг хариулт өгсөн байна. Энэхүү хөтөлбөр нь зорилтот өрх, хүн амын амьжиргааг дээшлүүлэх, хөдөлмөр эрхлэлт, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйлчилгээнүүдийг багцлан хүргэж, тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд хувь нэмэр оруулах зорилготой хэрэгжиж байгаа Монгол Улсын нийгмийн халамжийн тогтолцоонд үнэтэй хувь нэмэр оруулж байгаа хөтөлбөр гэж онцолсон байна.

“ЗӨХХСҮХ нь сурталчилгааны маш том ажлыг гүйцэтгэж байна. Миний бодлоор, нэг өрхийн амьжиргаа сайжрахад бусад нь хараад үүнийг даган дууриаж байна. Халамжийн тогтолцоон дах

¹² ХХҮЕГ, 2019. ЗӨХХҮХ-ийн 2019 оны тайлан

хамгийн гол хөтөлбөрүүдийн нэг. Үйлчилгээнүүдийн 50-70 хувь нь хөтөлбөрөөр дамжиж өрх, хүн амд хүрч байгаа бөгөөд өрхөд маш их тус дэм болж буй хөтөлбөр юм”¹³.

Гол мэдээлэгчдээс уг хөтөлбөр үндэсний хэмжээний бодлогын зорилтууд (Алсын хараа 2050; ТХЗ-ууд г.м)-тай хөтөлбөр хэрхэн уялдан холбогддог вэ гэж асуусан. Хөтөлбөрийн үр шим хүртэгчдээс бусад гол мэдээлэгчид (N=42)-ийн хариултыг нэгтгэн жагсаавал:

- Хөтөлбөр засгийн газрын мөрийн хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөө, нийгмийн халамжийн стратегийн баримт бичгүүдтэй уялдсан (15);
- Ядуурлыг бууруулах баримт бичигтэй уялдаатай (6);
- Ерөнхийдөө үндэсний хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдаа холбоотой (3);
- Хөдөлмөр эрхлэлтийг эмжих төсөл, хөтөлбөрүүдтэй илүү холбоотой (5);
- Алсын хараанаас илүүтэй ТХЗ-уудтай уялдсан (2);

Өрхийн хөгжлийн төлөвлөгөө бол ЗӨХХҮХ-ийн хэрэгжилтийг хангах маш чухал хэрэгсэл.

Өрхийн хөгжлийн төлөвлөгөө нь Монгол Улсын нийгмийн хамгааллын салбарын шинэчлэлийн нэг гол оролдлого мөн. Үндэсний хөтөлбөрийн үр шим хүртэгчдээс өрхийн хөгжлийн төлөвлөгөөний ач холбогдлыг тодруулахад, “бүгд” эерэг хариулт өгсөн байна. Ерөнхийдөө, зорилтот өрхийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулан, хэрэгжүүлснээр зарим өрхүүд амьжиргааны түвшингээ дээшлүүлж чадсан бол зарим өрхүүд хувь хүний хөгжил, нийгэмшихэд илүү ахиц дэвшилтэй байж чадсан гэж тэд үзэж байна. Зарим оролцогчдын хэлсэн онцлох хариултыг бүрэн эхээр нь дор оруулав:

“Амьдралд хэрэг болдог, амьжиргаанд ч нэмэр болж байна. Сургалтаар сурсан зүйлсээ амьдралд хэрэгжүүлээд, өрх гэрийн амьжиргаагаа сайжруулсан, эсгийгээр юм оёхыг сурсан, охиндоо заасан, одоо хамгийн наад зах нь углааш хийгээд зарж байна. Хөрш айлаа сургалтанд хамруулж, эсгий углааш хийх талаар өөрөө зааж сурсан амьжиргаанд нь сайнаар нөлөөлсөн”¹⁴.

“Төлөвлөгөө боловсруулсан, төлөвлөгөөний дагуу уялдуулаад явахаар амьдрал сайхан болдог юм байна. Ач холбогдлын хувьд сайн, өрхийн төсөв боловсруулах, хийх ажлаа төлөвлөдөг гэх мэт сургалтууд байдаг. Жишээ нь манай өрхийн хувьд 2 жилийн өмнө ажил хийдэг хүн байгаагүй, хүүхдүүд маань сургууль төгссөөгүй байсан. Эхлээд би өөрийгөө боловсрох хэрэгтэй юм гэж бодоод сургалтад хамрагдах хүсэлтээ өгөөд хамрагдсан. Мөн өрхийн хөгжил, төсөл хэрхэн бичих сургалтуудад хамрагдсан. Төлөвлөгөөндөө хүүхдүүдийнхээ ирээдүйд эзэмших мэргэжлийг тусгаж өгсөн. Хүүхдүүд маань насанд хүрээд ажил хөдөлмөр эрхлээд явж байна”¹⁵.

“Төлөвлөгөө боловсруулах нь сайн. Удирдамж болдог. Манайх Дэлхийн зөнгийн Төгсөлтийн аргачлалын төсөлд хамрагдсан. Хадгаламжийн бүлэгт орсон. Хадгаламж, хуримтлалын тухай сургалтад суусан. Өөрийгөө хүүхдээ хараад гэртээ байдаг хүн гэж бодохоо больсон. Өөрийн хүүхдүүддээ нийгэмших талаар заадаг”¹⁶.

¹³ Гол мэдээлэгчийн ярилцлага

¹⁴ Үр шим хүртэгчийн ярилцлага, Улаанбаатар

¹⁵ Үр шим хүртэгчийн ярилцлага, Улаанбаатар

¹⁶ Үр шим хүртэгчийн ярилцлага, Хөвсгөл

3.2 Хөтөлбөрийн үр дүн

Ихэнх оролцогч талууд хөтөлбөрийн зорилгыг сайн мэдэж байгаа ч хөтөлбөрийн үр дүнгийн талаар өөр өөр байр суурьтай, хэрэгжилт орон даяар ялгаатай байна гэжээ.

Гол мэдээлэгчид (ө.х. удирдах ажилтан, аймаг/дүүрэг/сум/хорооны ажилтнууд, Хамтарсан баг болон Амьжиргааг дэмжих зөвлөлийн төлөөлөл) үндэсний хөтөлбөрийн зорилго, зорилтыг маш сайн мэдэж байна. Тэд ЗӨХХСҮХ бол зорилтот өрхийн амьжиргааг дээшлүүлж, бие даан амьдрах чадвартай болгох, улмаар тэдний зан үйлийг өөрчлөх зорилготой гэдгийг дуу нэгтэй батлан хэлж байна.

Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт орон даяар нэлээд ялгаатай байна гэж гол мэдээлэгчид үзэж байна. Учир нь хөтөлбөрийн хэрэгжилт оролцогч талуудын идэвх оролцоо, хандлага, санхүүжилт, орон нутгийн санаачлагаас ихээхэн хамаарч байна.

“Өрхийн гишүүдийн идэвх оролцоо их чухал. Сургалтанд суу гэхээр ирэхгүй. Ганц нэг өдөр ажиллаж байгаад алга болдог хүмүүс ч бий. Залуучуудын оролцоо муу байна. Сургалтанд ирсэн залуучууд итгэлтэй, дуртай болдог. Зорилтот өрхийн айл гэж хэлүүлэхээсээ санаа зовдог”¹⁷.

“Хөтөлбөр өөрийн зорилгоо биелүүлж байгаа. Ямар ч тохиолдолд өрхийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлсэн өрхүүдийн амьжиргаа дээшилсэн гэж бодож байна. Гэхдээ, хөтөлбөрийн хэрэгжилт санхүүжилт, хүний нөөцийн чадавхиас ихээхэн хамаарна. Нэмж хэлэхэд, иргэдийн оролцоо маш чухал”¹⁸.

Нийгмийн халамжийн ажилтнуудын идэвхтэй, эрчимтэй оролцоо ЗӨХХҮХ-ийн хэрэгжилт амжилттай байх гол түлхүүр. Нийгмийн ажилтан сонгогдсон өрхийн эрэлт хэрэгцээг тусгасан өрхийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулахад тусалж, түүний ахиц дэвшлийг тогтмол хянаж, үнэлж байх ёстой. Гол мэдээлэгчдийн тэмдэглэснээр, нийгмийн ажилтнууд ажлын цаг хүрэлцэхгүй, ачаалал хэт өндөр, ойр ойрхон солигддог, сургалтанд хангалттай хамрагдаж чадаагүй, тэднийг урамшуулах хөшүүрэг сул байдаг аж. Тэдний хариултыг дор нэгтгэн харуулбал:

- Энэ бол яах аргагүй нийгмийн халамжийн ажилтны ажил мөн (22 гол мэдээлэгч, 20 үр шим хүртэгчийн хариулт);
- Нийгмийн ажилтнуудын ажлын ачаалал маш их. Тийм учраас, сум/хорооны түвшинд орон тоог нэмэгдүүлж, нэг хүн дангаар хөтөлбөрийг хариуцдаг болбол хөтөлбөрийн хэрэгжилт үр дүнтэй байна (10 мэдээлэгчийн хариулт);
- Нийгмийн халамжийн ажилтнууд маш их ачаалалтай байдаг. Иймд сайн дурын ажилтан ажиллуулбал илүү үр дүнтэй (5 гол мэдээлэгчийн хариулт);
- Нийгмийн ажилтан хариуцан хийх ёстой, гэхдээ Хамтарсан багийн оролцоог эрс сайжруулах хэрэгтэй (4 оролцогчийн хариулт);
- Нийгмийн ажилтан мэргэжлийн хүн байх ёстой. Одоогоор тэдний дийлэнх нь санхүүгийн мэргэжлийн хүмүүс байдаг. Учир нь мөнгөтэй харьцдаг гэдэг утгаар. Хэрвээ халамжийн ажилтан мэргэжлийн нийгмийн ажилтан байвал хөтөлбөрийг хариуцан ажиллаж болно (зөвхөн нэг хариулагчийн өгсөн хариулт).

¹⁷ Гол мэдээлэгчийн ярилцлага, Хөвсгөл

¹⁸ Гол мэдээлэгчийн ярилцлага, Улаанбаатар

Гол мэдээлэгч болон үр шим хүртэгчдийн зарим хариултаас дор ишилбэл:

“Нийгмийн ажилтнууд маш завгүй байдаг. Тэд бараг 60 гаруй халамжийн үйлчилгээ, дэмжлэгийг өрх, хүн амд хүргэхээр шаргуу ажилладаг. Сайн дурын ажилтан, тухайлбал, тэтгэвэрт гарсан хүмүүс, залуучуудыг ажиллуулбал их зүгээр. Тэднийг идэвхжүүлж, сэдэлжүүлэх хэрэгтэй”¹⁹.

“Сум/хорооны түвшинд ажиллаж байгаа нийгмийн ажилтнууд өрх, хүн амаа сайн мэддэг. Иймд хөтөлбөрийг өрхөд хүргэх ажлыг тэд хийх ёстой. Гол нь тэднийг тогтвортой ажиллуулах, тээгэхгүй бол байнга солигддог”²⁰.

“Нийгмийн ажилтан, халамжийн ажилтан хөтөлбөрийг өрхөд хүргэх нь зүйтэй. Гэхдээ тэд маш завгүй ажилладаг, гэвч тэд өрхөө сайн таньдаг, мэддэг. Тэдний ажын ачааллыг бууруулах хэрэгтэй. Хөтөлбөрийн хүрээнд сонгогдох өрхийн квотыг бууруулбал сайн. Хорооны түвшинд. Ингэвэл Дэлхийн зөнгийн төсөл шиг өрх нэг бүрт хүрч ажиллаж чадна”²¹.

“Энэ бол нийгмийн ажилтны үндсэн ажил. Гэхдээ хэрэгжилтийг хангах байдал түвшин бүрт харилцан адилгүй, санхүүжилт, цаасны ажил, ажлын ачаалал зэргээс ихээхэн шалтгаалдаг”²².

Мэдэгдэхүйц үр дүн харагдахгүй, хөтөлбөрийн хяналт шинжилгээ муу байсан нь гол асуудал мөн болж байна. Нийгмийн ажилтнууд сонгогдсон өрхүүдийг үйлчилгээ, сургалтуудад зуучилж, тэдний оролцоог бүртгэн авдаг. Гол мэдээлэгчийн ярьснаар бол хэрэгжилтийн хяналт-шинжилгээ байхгүй, хэрвээ өрх 2-оос 3 үйлчилгээнд хамрагдаад оролцсон бол тайланг үндэслэн “амьжиргаа дээшилсэн” гэж тэмдэглэн авдаг байна.

“Хөтөлбөр зорилгоо биелүүлэхгүй байгаа. Учир нь сумын түвшинд өрх нэг бүртэй ойрхон тулж ажиллахгүй байна. Өрхийн ахиц, дэвшилийг нийгмийн ажилтан үнэлдэггүй. Өрхийн нөхцөл байдлыг өрхөд очихгүйгээр гаднаас нь шууд үнэлж байна. Өрх бүр өрхийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулдаггүй. Ийм учраас, хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан худлаа, бодитой биш байдаг”²³.

ЗӨХХҮХ-ийн хүрээнд хүргэсэн багц үйлчилгээнүүдийн үр дүнгийн талаар тэд ялгаатай байр суурьтай байна. Багцаар хүргэж буй үйлчилгээнүүд дундаас өрхийн хэрэгцээг хангаж чадсан ямар үйлчилгээ байгааг тодруулахад дараах хариултууд хамгийн их давхцалтай байна. Үүнд:

- Эрүүл мэндийн үйлчилгээ;
- Бүх төрлийн сургалт, зөвлөгөө;
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, ялагуяа, ажлын байрны зуучлал, хагас цагийн болон түр зуурын хөдөлмөр эрхлэлтийн зуучлал, олон нийтийг хамарсан ажил;
- Нийгмийн халамжийн үйлчилгээнүүд, тухайлбал, хүнсний талон, хоол хүнс, хувцас хунар олголт;
- Бүлгийн ажил, тухайлбал, ногоо тарих, оёдол хийх гэх мэт.

Мөн гол мэдээлэгчдийн хэлж байгаагаар, хөтөлбөрт хамрагдаж байгаа өрхүүд материаллаг болон санхүүгийн дэмжлэг авах их сонирхолтой байдаг аж. Харамсалтай нь, үндэсний хөтөлбөрийн хүрээнд энэ төрлийн тусламж дэмжлэг үйлчилгээ хязгаарлагдмал байдаг байна.

¹⁹ Гол мэдээлэгчийн ярилцлага, Хөвсгөл

²⁰ Гол мэдээлэгчийн ярилцлага, Улаанбаатар

²¹ Гол мэдээлэгчийн ярилцлага, Улаанбаатар

²² Гол мэдээлэгчийн ярилцлага

²³ Гол мэдээлэгчийн ярилцлага, Хөвсгөл

Мөн тэдний хариултаар бол, өрхүүд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төслийн сонгон шалгаруулалтын шалгуурыг хангаж чаддаггүй байна. Ийм учраас, зөвхөн ажлын байрны зуучлал, эсвэл олон нийтийн ажилд л оролцох боломжтой байдаг байна.

Хэдийгээр энэ үнэлгээ үр нөлөөг үнэлэх зорилготой биш ч судалгааны үр дүнгээр, хөтөлбөрийн үр нөлөө нэлээд холимог, тухайлбал, идэвхтэй өрхүүдийн хувьд хөтөлбөр ихээхэн үр дүнтэй, харин идэвх муутай өрхүүдийн тухайд үйлчилгээ болоод сургалтын үр нөлөө бага байсныг харуулж байна. Энэ нь нэг талаас үндэсний хөтөлбөр потенциал үр нөлөөтэй байсан гэдгийг харуулж буй хэрэг юм.

Үр шим хүртэгчдийн өгсөн зарим хариултыг дор өгүүлвээс:

“Манай өрхийн хувьд уг хөтөлбөрт хамрагдсанаар өрхийн хөгжлийн зорилго, зорилтоо эхнээс нь биелүүлээд явж байна гэж бодож байгаа. Яагаад гэвэл нийтдээ 3 удаа ногооны аж ахуй, хүлэмжийн аж ахуй гэх мэт чиглэлээр 2018, 2019, 2020 онуудад сургалтад хамрагдсан. Ногооны аж ахуйн сургалтад хамрагдсанаар гэрээр ногоо тарихад суралцсан. Сүүлийн 3 жилд өөрийн хашаанд ногоо тариад өөрийн өрхийн хэрэгцээг хангахаас гадна бага ч гэсэн хэмжээгээр борлуулах боломжтой болсон. Ирэх жилээс хүлэмжээ хөгжүүлж аж ахуйн хэлбэрт оруулна гэж бодож байгаа. Энэ онд сүү сүүн бүтээгдэхүүний төсөл бичиж буцалтгүй тусламжаар 700 мянган төгрөг авсан. 4 үнээтэй, тэднээс сүүгээ саагаад цагаан идээ боловсруулаад, тараг өрөм аарцаа боловсруулаад зардаг”²⁴.

“Биелүүлж байна. Хамгийн наад зах нь хөгжлийн бэрхшээлтэй хэвтрийн хүүхдээ хэрхэн арчлах вэ гэдэгт нөхөр бид 2 суралцсан, сурснаа бусдад бас хэлж зааж өгсөн. Би ч их юм сурсан, хүүхдээ асрах сургалтаас гадна, мод ногоо тарих гэх мэт сургалтуудад хамрагдсан. Хүүхдээ өдрийн эмчилгээ, сэргээн засах эмчилгээнд хамруулдаг гээд л бидэнд хэрэгтэй зүйлсийг чиглүүлж өгч байгаа нь бидний зорилгыг хангаж чадаж байна. Туршлага хуваалцах аялалд хүртэл оролцож Дархан, Булган гээд л 2018 онд яваад ирсэн”²⁵.

“Би 2011 он машины осолд ороод хөгжлийн бэрхшээлтэй болсон. Манай өрх Дэлхийн зөнгийн болон үндэсний хөтөлбөр хоёуланд нь хамрагддаг. Төслөөс 2018 онд 1,500,000 төгрөгийн буцалтгүй тусламж өгсөн. Түүгээрээ хувилагч машин, принтер авч, тоног төхөөрөмжөө ерөнхийд нь шинэчилсэн. Өрхийн орлого эрс нэмэгдсэн. Би охиныхоо сургалтын төлбөрийг төлөх чадвартай болсон. Сэтгэл ханамж маш өндөр байна”²⁶.

“Би ганц бие, олон хүүхэдтэй эх. Гэрээрээ юм оёдог. Дэлхийн зөнгийн төсөлд хамрагдсан. Төслөөс оёдлын машин авч өгсөн. Харин үндэсний хөтөлбөрийн хүрээнд хорооноос дуудаж сургалтанд л хамруулдаг. Бизнес, аж ахуй эрхлэлтийн сургалт маш хэрэгтэй байсан. Харин эрүүл ахуй, эрүүл мэндийн сургалтууд ач холбогдол багатай санагдсан. Миний бодлоор, хөтөлбөр, төсөлд хамрагдах хүнээ, өрхөө зөв сонгох ёстой, тэгвэл их үр дүнтэй байна гэж боддог. Архины хамааралтай ч юм уу ажил хийхийг хүсдэггүй хүмүүсийг хүчлээд хэрэггүй”²⁷.

Үнэлгээнд оролцсон өрхүүдийн дийлэнх нь өрхийн хөгжлийн гурвалжинг сайн мэдэхгүй байна. Оролцогчдоос “Өрхийн хөгжлийн гурвалжин” арга зүй өрхийн хэрэгцээг үнэлж чадаж буй эсэхийг тодруулахад, үр шим хүртэгчдийн 85.6 хувь буюу 24 өрх энэхүү арга

²⁴ Үр шим хүртэгчийн ярилцлага, Улаанбаатар

²⁵ Үр шим хүртэгчийн ярилцлага, Улаанбаатар

²⁶ Үр шим хүртэгчийн ярилцлага, Улаанбаатар

²⁷ Үр шим хүртэгчийн ярилцлага, Улаанбаатар

зүйг “мэдэхгүй” байна. Үнэлгээний гурвалжинг мэддэг өрх цөөн (ердөө 4-хөн өрх) байгаа бөгөөд хөтөлбөрт хамрагдсан цагаасаа өрхийн дэвтэр хөтөлж, үнэлгээгээ хийсээр иржээ.

“Үндэсний хөтөлбөрт хамрагдсанаа мэдээгүй. Манайх Дэлхийн зөнгийн төсөлд хамрагдсан байсан. Үнэхээр үндэсний хөтөлбөрт хамрагдсанаа ерөөсөө мэдээгүй. Заримдаа сумаас дуудаж янз бүрийн арга хэмжээнд оролцуулаад байдаг”²⁸.

Нийгмийн ажилтнууд болон өрхүүдэд зориулсан сургалт хангалттай зохион байгуулагдаагүй нь гол асуудал болжээ. Сургалт хангалттай зохион байгуулагдаагүй, өрхийн хөгжлийн төлөвлөгөөний арга зүйн гарын авлага хангалтгүй, үнэлгээний асуудал зэрэг нь гол сорилт болжээ. Үндэсний болон орон нутгийн түвшинд 2016 онд л ганц удаа сургалт зохион байгуулагдсан. Өрхийн хөгжлийн төлөвлөгөө, түүний үнэлгээнд маш олон үзүүлэлт (38) ашиглах тул нийгмийн ажилтан болон өрхүүдэд зориулсан сургалтыг тогтмол, тасралтгүй явуулах нь чухал байсан. Харамсалтай нь сургалт маш хангалтгүй хийгдсэн тул үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт хангалтгүй байх үндэслэл болж байна²⁹.

“Хөтөлбөрийн зорилго нь дундаж өрхийн хандлагыг өөрчлөх, дэмжлэг үзүүлэх. Өөрөөр хэлбэл загас барих аргыг нь заана гэсэн үг. Өрх хэрхэн хөгжиж болох вэ, хэрхэн амьжиргаагаа сайжруулж болох вэ, хэрхэн тэдэнд дэмжлэг болж болох талаас сургаж хөгжүүлнэ”³⁰.

Хүснэгт 3-т ЗӨХХҮХ-ийн институцийн холбогдолтой боломж, бэрхшээлийн талаар нэгтгэн харуулав. Гол мэдээлэгчид (ө.х. удирдах ажилтан, аймаг/дүүрэг/сум/хорооны ажилтнууд, Хамтарсан баг болон Амьжиргааг дэмжих зөвлөлийн төлөөлөл) үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд нэг талаас боломж, нөгөө талаас бэрхшээл цөөнгүй байсныг дурьджээ. Хамгийн их давтагдсан хариултыг нэгтгэвэл,

Хүснэгт 3: Институцийн түвшин дэх боломж, бэрхшээлүүд

Боломж	Бэрхшээл
Өрхийн амьжиргаа дээшилсэн	Санхүүжилтгүй
Хувийн бизнес, аж ахуй эрхлэх арга барилд суралцсан	Өрхийн сөрөг хандлага, хойрго байдал
Хөдөлмөр, халамжийн үйлчилгээг хүргэх боломж бүрдсэн	Орон нутгийн байгууллагуудын хамтын ажиллагаа сул
Өрхүүд эрхээ эдлэх боломжтой болсон	Орон нутгийн удирдлагын дэмжлэг байхгүй
Өрхийн зан үйл, сэтгэлгээг өөрчилсөн	Нийгмийн ажилтнуудын ажлын хэт их ачаалал
Өрхийн гишүүдийн идэвх оролцоог нэмэгдүүлж, нийгэмшүүлсэн	Хүний нөөцийн чадавхи муу
Гэр бүлийн харилцаа сайжирсан	Үндэсний хөтөлбөрийн ач холбогдлыг мэдэхгүй, ойлгодоггүй
Нийгмийн үйлчилгээг танил тал гэлгүйгээр хүргэх боломж олгосон	Сургалтын гарын авлага, материалын хүртээмж муу
	Өрхүүд сургалт, олон нийтийг хамарсан үйл ажиллагаанд оролцох идэвх сул
	Архины хамааралтай өрх, хүн амтаы харилцахад маш хүнд

Харин үр шим хүртэгчдээс өрхийн хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх явцад гарсан боломж, бэрхшээлийг тодруулахад дараах хариултуудыг өгчээ. Үүнд:

²⁸ Үр шим хүртэгчийн ярилцлага, Хөвсгөл аймаг

²⁹ Гол мэдээлэгчийн ярилцлага, Улаанбаатар

³⁰ Гол мэдээлэгчийн ярилцлага, Улаанбаатар

Хүснэгт 4: Өрхийн түвшин дэх боломж, бэрхшээлүүд

Боломж	Бэрхшээл
Амьжиргаа дээшилсэн	Санхүүгийн нөөц
Төсөл боловсруулах, хэрэгжүүлэх арга зүйд суралцсан	Мэдээллийн дутмаг байдал
Буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээл зэрэг санхүүгийн дэмжлэг авсан	Өрхийн гишүүдийн хувь хүний хөгжил сул
Бизнес төлөвлөгөөтэй болсон	Төсөл хэрэгжүүлэх ур чадваргүй
Аж ахуй эрхлэх ур чадвар эзэмшсэн	Багаар ажиллах чадваргүй
Бизнесийн эргэлтийн хөрөнгөтэй болсон	Төслийн хэрэгжилтийн тайлан гаргаж мэдэхгүй
Өрхийн амьдралын нөхцөл дээшилсэн	Ажилд хандах хандлага муу
Өрхийн гишүүдийн нийгмийн оролцоо нэмэгдсэн	Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа дэндүү богино
Нийгмийн суурь үйлчилгээ, халамжийн үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээг авах боломж бүрдсэн	Зорилтот өрхөд бусад өрхүүдээс үзүүлэх таагүй хандлага

Өрхүүд Дэлхийн зөнгийн Төгсөлтийн аргачлалын төсөлд хамрагдвал үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт мөн уг өрх дээр сайн харагдаж байна. Энэхүү үнэлгээний дүнгээс харахад, зорилтот өрхийн хөгжлийн үндэсний хөтөлбөрт зөвхөн хамрагдвал үр дүн багатай байна. Дэлхийн зөнгөөс 2017-2020 онд Улаанбаатар хотын (Сонгинохайрхан, Баянзүрх дүүрэгт) 600 өрх, 2019-2021 онд Өвөрхангай аймгийн 320 өрхийг хамруулсан Төгсөлтийн аргачлалын төслийг хэрэгжүүлсэн байна. Төслийн гол зорилго бол бүх зорилтот өрхийг ядуурлын хүнд хэлбэрээс ангижруулж төгсгөх, бие физиологи, сэтгэцийн эрүүл мэндийн хувьд сайжирч, тогтвортой амьжиргааг бий болгох чадварыг нийгэмд бий болгох явдал байв. Улаанбаатар хотод “Төгсөлтийн аргачлал - 600” төслийг хэрэгжүүлж, 36 сарын туршид 600 зорилтот өрхтэй тулж ажиллан, өнгөрсөн жилийн 6-р сард дуусгасан байна. Оролцогч талуудын ярилцлагаас харахад, оролцогчдын 90 орчим хувь нь 36 сарын дараа Дэлхийн зөнгийн оролцоо, ахиц дэвшлийн шалгуур үзүүлэлтэд тэнцэж, төгссөн байна. Мөн түүнчлэн, Дэлхийн зөн олон улсын байгууллага нь “Төгсөлт 600” төсөлд хамрагдсан зорилтот өрхийн эрүүл мэнд, сэтгэхүй, эдийн засгийн өөрчлөлтийг хэмжих зорилгоор СИКА ХХК-ийн судалгааны багаар үнэлгээ хийлгэсэн байна. Үнэлгээний үр дүнгээр, оролцогчдын 84.6 хувь нь амьдралаа өөрчилж чадсан, төслийн үйл ажиллагаа, сургалтанд оролцооноор маш олон эерэг үр дүн гарсан гэжээ. Тэдний 30 гаруй хувь нь олон найз нөхөдтэй болж, өрхийн орлого нэмэгдсэн, мөн гэр бүлийн харилцаа тогтвортой сайхан болсон байна. Эдгээр үр дүнгээс харахад, зорилтот өрхөд чиглэсэн үйл ажиллагаанууд өрхийн хэрэгцээг хангаж чадсан байна. Төслийг хэрэгжүүлэх явцад оролцогчдын 83.4 хувь нь мэргэжлийн болон техникийн сургалтад хамрагдсанаар өрхийн орлогоо нэмэгдүүлсэн байна. Мөн 94.1 хувь нь үйлдвэрлэлийн процесст оролцож, төслийн дүгээс хөрөнгийн дэмжлэг авснаар өрхийн орлогоо нэмэгдүүлж чаджээ. Энэ нь төслийн үр өгөөж үнэхээр өндөр байгааг илтгэж байна.

ЗӨХХСҮХ-ийн болон Төгсөлтийн аргачлалын гол үйл ажиллагаа, авч хэрэгжүүлж буй арга хэмжээг зарим сонгосон үзүүлэлтүүдийн хүрээнд харьцуулан Хүснэгт 5-д харууллаа. Дэлхий зөнгийн Төгсөлтийн аргачлалын төсөлд давхар хамрагдсан өрхүүдийн амьжиргааны түвшин мэдэгдэхүйц дээшилжээ. Учир нь Дэлхийн зөнгийн төсөл нь ТББ-ын хөтөлбөр, мөн өрхтэйгээ нэг бүрчлэн тулж ажилладаг, өрхөд зарцуулах хөрөнгө хугацаа, хүн хүчээ шийдсэн байдагтай холбоотой байна.

Хүснэгт 5: ЗӨХХҮХ болон Төгсөлтийн аргачлал хоорондын харьцуулалт, зарим сонгосон үзүүлэлтээр

Үзүүлэлт	ЗӨХХҮХ	Төгсөлтийн аргачлал
Өрхийн сонголт	Өрхийн мэдээллийн нэгдсэн сангийн 409-с доош буюу нийгмийн халамжийн тусламж дэмжлэг зайлшгүй шаардлагатай өрх	Хамгийн ядуу өрхүүдээс өөрсдийн шалгуураар сонгоно. Гол шалгуур нь ажиллах чадвартай, ажиллахад бэлэн, нийгмийн халамжийн ядаж нэг хөтөлбөр, тухайлбал, Хүнсний талон гэх мэтэд хамрагддаг байх
Хөтөлбөрт хамрагдах өрхийн тоо	Квот	Хязгаарлагдмал
Хамрагдаж буй хугацаа	Нэг жил	2-3 жил
Санхүүжилт	Төсөвлөгдсөн санхүүжилт байхгүй	Төсөвт санхүүжилттэй
Хариуцаж ажиллах нэгж/хүн	Нийгмийн халамжийн ажилтан	Сайн дурын ажилтан
Нэг ажилтанд ногдож буй өрхийн тоо	40-50 өрх	8-10 өрх
Хөрөнгийн дэмжлэг бий эсэх	Байхгүй	Техник, тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлдэг
Сургалтад хамруулдаг эсэх	Бусад төсөл, хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулж буй сургалтуудад зуучлагдан хамрагддаг	Тусгайлсан, сэдэвчилсэн сургалтуудыг өрхийн хэрэгцээнд тулгуурлан зохион байгуулж, хамруулдаг
Өрхийн амьжиргаанд гарч буй өөрчлөлт	Бага	Өндөр

3.3 Хөтөлбөрийн тогтвортой байдал

ЗӨХХҮХ нь санхүүгийн нөөцийн хувьд дутагдалтай. Гол мэдээлэгчид хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд ямар нэгэн батлагдсан төсөв байхгүй, санхүүжилтгүй байсан гэжээ. Иймд хөтөлбөрийн санхүүжилтийн хамгийн үр ашигтай арга хэрэгсэл, тогтолцоог бий болгох хэрэгцээ шаардлага байна гэж үзжээ. Сонгогдсон өрхийн амьжиргааг ямар нэгэн санхүүжилтгүйгээр нэмэгдүүлнэ гэдэг нь бодитой бус, хэрэгжүүлэх боломжгүй зүйл гэж тэд мөн үзэж байна.

“Уг хөтөлбөр зорилго, зорилтоо биелүүлж чадахгүй байгаа. Яагаад гэвэл мөнгө хөрөнгө байхгүй, удирдлагын дэмжлэг байхгүй. Сумандаа энэ хөтөлбөрөө хариуцсан дагнасан ажилтантай байвал зүгээр. Сум, баг дээр ачаалал ихтэй учир болдоггүй”³¹.

“Зарим арга хэмжээ, үйл ажиллагааг Халамжийн сангийн буцаагдсан орлогоос санхүүжүүлдэг. Уг нь хөтөлбөр засгийн газрын нөөц сан болоод орон нутгийн төсвөөс санхүүжүүлж зүгээр. Харамсалтай нь, орон нутгийн зүгээс ямар ч төсөв хуваарилагдаагүй”³².

“Хэрхэн санхүүждэгийг би мэдэхгүй. Нийгмийн халамжийн ажилтнууд заримдаа бага зэргийн зардал (ө.х. шатахууны зардал, сургалтын зарим зардал, бичиг хэргийн зардал гэх мэт)-ыг өөрсдийн

³¹ Гол мэдээлэгчийн ярилцлага, Хөвсгөл аймаг

³² Гол мэдээлэгчийн ярилцлага, Хөвсгөл аймаг

халааснаас болоод цалингаасаа гаргадаг. Орон нутгийн удирдлагууд хөтөлбөрийн ач холбогдлыг ойлгож, санхүүжилтэд анхаарах хэрэгтэй”³³.

“ТББ-ын хандив, бусад халамжийн үйлчилгээ, хөтөлбөр, сайн дурын компани аян, төрийн үнэ төлбөргүй үйлчилгээний хүрээнд үйл ажиллагаануудаа явуулдаг. Тусгайлан хуваарилсан төсөв байхгүй. Хэрвээ хөтөлбөрийг үргэлжлүүлнэ гэвэл санхүүжилтийн асуудлыг нэн тэргүүнд шийдэх ёстой”³⁴.

“Хуваарилагдсан төсөв байхгүй. Гэвч заримдаа Амьжиргааг дэмжих зөвлөлийн дэмжлэгтэйгээр бага зэргийг төсөв батлагддаг. Хувь хүн, байгууллага, ТББ-аас хандив гуйдаг. Санхүүгийн нөөц бололцоо хайна гэдэг хамгийн том асуудал байна”³⁵.

Үнэлгээнд оролцогчдын үзэж байгаагаар, хөтөлбөрийн санхүүжилтийг нэг талаас, өрхийн аж ахуй, амьжиргааг дэмжихтэй холбоотой, нөгөө талаас, захиргааны буюу хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой удирдлага, зохион байгуулалт, сургалт, сурталчилгааны үйл ажиллагаатай холбоотойгоор төсөвлөн шийдвэрлэх хэрэгтэй байна. Мөн, зарим оролцогчдын тэмдэглэснээр, хөтөлбөрийн санхүүжилт, дэмжлэгийн суурийг олон талт байдлаар бий болгох хэрэгцээ шаардлага байна. Санхүүгийн дэмжлэгийг олон эх үүсвэр, янз бүрийн түвшинд бий болгох. Олон талт санхүүгийн эх үүсвэрт буцалтгүй тусламж, бусад эх үүсвэрүүдийн гэрээ, жишээлбэл, хувийн эх үүсвэр, үйлчилгээний төлбөр, эргэн төлөгдөх үйлчилгээнүүд, сайн дурынхан, хандив, эд зүйлсийн тусламж, хөрөнгө босгох гэх мэт орно. Мөн түүнчлэн, ихэнх оролцогчдын хувьд хөтөлбөрийг хэт богино хугацаанд, ямар нэг санхүүжилтгүйгээр хэрэгжүүлэх нь сайн үр дүн, үр нөлөөг авчрахгүй, ийм үр дүнг хүлээх ч хэрэггүй гэжээ.

ХНХЯ нь хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад авсан **сургамжууд** юу болох талаар тодруулахад, оролцогчдын ихэнх нь дараах хариултыг өгсөн байна. Үүнд:

- Нийгмийн ажилтнуудын ур чадвар, санаачлага, ойлголтыг сайжруулахад анхааран ажиллах хэрэгтэй байсан чадавхжуулах ажил сайн хийгдээгүй;
- Туршлага солилцох уулзалтуудыг тогтмол зохион байгуулах ёстой ч хангалттай хийгдээгүй;
- Бусад төсөл, хөтөлбөртэй уялдаа холбоотой, хамтран ажиллахад яамны зүгээс анхаарах ёстой. Гэтэл энэ ажил хангалттай түвшинд хийгдээгүй;
- Нийгмийн ажилтнуудын ажлын ачааллыг тэнцвэрүүлэхэд анхааран ажиллаагүй;
- Агентлаг хоорондын зохицуулалтыг сайжруулахад манлайлал үзүүлээгүй;
- Нөөцийг бий болгоход манлайлал гаргаж чадаагүй;
- Ухуулга сурталчилгаа, олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх кампанит ажил дутмаг хийгдсэн;
- Санхүүжилтийн боломж хайх.

Бараг судалгаанд оролцсон бүх оролцогчид үндэсний хөтөлбөрийг цаашид үргэлжлүүлэх хүсэлтэй байна. Хэрвээ хөтөлбөрийг үргэлжлүүлнэ гэвэл, дараах асуудлыг шийдсэн байвал зохилтой гэж тэд үзэж байна. Үүнд:

- Салбар хоорондын зохицуулалтын талаар хууль, эрхзүйн баримт бичгүүдэд тусгах;

³³ Гол мэдээлэгчийн ярилцлага, Хөвсгөл аймаг

³⁴ Гол мэдээлэгчийн ярилцлага, Улаанбаатар

³⁵ Гол мэдээлэгчийн ярилцлага, Улаанбаатар

- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, МСҮТ-ийн талаарх бодлогын баримт бичигт зорилтот бүлэг эсвэл өрхийн талаар тодотгож өгөх;
- Улсын болон орон нутгийн төсөв санхүүжилт төлөвлөх;
- Нийгмийн халамжийн шинэчилсэн хуульд үндэсний хөтөлбөрийн үзэл баримтлал, зорилгыг тусгах;
- Төгсөлтийн арга гэх мэт ижил төстэй төсөл, хөтөлбөртэй уялдаа холбоотой байх;
- Хөтөлбөрийн чанар, ач холбогдол, үр дүнг сайжруулахад анхаарах.

Гол мэдээлэгчид мөн хөтөлбөрийн тогтвортой байдлыг хангахын тулд ядаж дараах 5 стратегийг анхаарах хэрэгтэй гэж үзэж байна. Үүнд:

- Чанарын тасралтгүй сайжруулалтыг бий болгох, үнэлэх;
- Байгууллагын чадавхийг нэмэгдүүлэх;
- Түншлэлийг өргөжүүлэх;
- Санхүүжилтийн шинэ урсгал, олон төрөлт эх үүсвэрийг бий болгох, тодорхойлох;
- Бодлогын өөрчлөлт, шинэчлэл хийх.

4 Хэлэлцүүлэг

4.1 Дүгнэлт

Зорилтот өрхийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр (2016-2020) 2016 онд Засгийн газрын 16 дугаар тогтоолоор батлагдсан. Тус хөтөлбөр нь ТХЗ-уудын хүрээнд өрхийн амьжиргааг дээшлүүлэхийн тулд өрхийн хэрэгцээнд үндэслэн боловсрол, эрүүл мэнд, халамж, хөдөлмөр эрхлэлт, санхүүгийн үйлчилгээг багцлан зохион байгуулалттайгаар хүргэх зорилготой.

Энэхүү хөтөлбөр нь Монгол Улсын нийгмийн халамжийн тогтолцоонд гол үүргийг гүйцэтгэж, зорилтот өрхийн амьжиргааг дээшлүүлэхэд хувь нэмэр оруулж байна. Хөтөлбөр үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, улс орны хөгжлийн тэргүүлэх чиглэлтэй нийцтэй байна.

Хөтөлбөрийн хэрэгжилт орон даяар харилцан адилгүй байна. Энэ нь оролцогч талуудын хандлага, ажилтнуудын чадавх, санхүүжилт, орон нутгийн удирдлага, санаачлагаас ихээхэн хамаарч байна. Үндэсний хөтөлбөр дэх өрхийн хөгжлийн төлөвлөгөө бол зорилгодоо хүрэх маш сайн арга хэрэгсэл бөгөөд энэхүү төлөвлөгөө нь өрхийн гишүүд хамтдаа өөрсдийн өрхийн хэрэгцээгээ тодорхойлох, үнэлгээ хийхэд оролцооны аргад түшиглэсэн байдлаар хийхэд дэмжлэг болж байна. Өрхийн хөгжлийн гурвалжин арга зүйг цаашид хялбаршуулахын тулд сайжруулах хэрэгтэй байна.

Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт нэг талаас санхүүжилт, нөөцийн дутмаг байдал, нөгөө талаас, дээд түвшин дэх шийдвэр гаргалт муу байсантай холбоотой байна. Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ямар нэг санхүүжилт хуваарилагддагүй, төсөвлөгддөггүй байна. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад агентлаг, үйлчилгээ хоорондын хамтын ажиллагаа, манлайллыг хангах, санхүүжилтийн боломж эрэлхийлэх, нийгмийн халамжийн ажилтнуудын ачааллыг тэнцвэржүүлэх, олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх кампанит ажил зохион байгуулах гэх мэтэд манлайлал дутагдалтай байсныг оролцогчид мөн цохон тэмдэглэжээ.

Энэхүү тайлангийн ерөнхий үр дүн бол дэлхийн хэмжээнд хэрэглэгдэж байгаа ижил төстэй хөтөлбөрүүдийн хэрэгжилтээс сургамжуудыг батлах нотлох явдал байсан³⁶. ТББ-ын хэрэгжүүлсэн Төгсөлтийн аргачлал хөтөлбөр сайн хэрэгжсэн. Учир нь орон нутгийн түвшний хүний нөөцөөр сайн хангагдсан, маш сайн боловсруулагдсан сургалтын хөтөлбөртэй, эргэлтийн хөрөнгө хуваарилсан, тухайлбал, мал эсхүл бизнес эрхлэх зээл гэх мэт. Нөгөө талаас, ийм аргаар засгийн газрын хөтөлбөрийг хэрэгжүүлнэ гэвэл олон салбар дундын зохицуулалтыг хийхэд хүндрэлтэй, нийгмийн ажилтнууд үргэлжид цаг хугацааны хувьд хязгаарлагдмал байдаг зэрэг нь нөлөөлж болзошгүй. Дэлхийн хэмжээнд хэрэгжсэн төгсөлтийн аргачлалаас сургамж³⁷ авахад, засгийн газрын түвшинд ийм төрлийн хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэхдээ сайн бодож тунгаах хэрэгтэй байна. Мөн хөтөлбөрийг хэрэгжүүлж дууссанаар оролцогчид юуг төгсгөх вэ гэдгийг тодорхойлох, үйл ажиллагааны хүрээг маш сайн тодотгох хэрэгтэй. Түүнчлэн, хэрхэн хэмжих, халамжийн хөтөлбөрөөс

³⁶ <https://onlinelibrary.wiley.com/doi/10.1111/1759-5436.12124>

³⁷ Латин Америкийн орнуудад хэрэгжсэн хөтөлбөрүүдийн тухай эндээс харна уу.

<https://socialprotection.org/discover/blog/integrating-graduation-cash-transfer-programs-experiences-latin-america>

“гарснаар” үр шим хүртэгчдийг “төгссөн” гэж үзэх үү? гэх мэт олон асуултад хариулах хэрэгтэй болно. Төгсөлтийн хөтөлбөр сайн хэрэгжинэ гэдэг нь үр шим хүртэгчид хэмжигдэхүйц хөгжлийн үр дүнд тогтвортойгоор хүрч, хөтөлбөр дуусахад энэхүү ахиц дэвшил урт хугацаанд тогтвортой байх ёстойг хэлнэ. Мөн тухайн хөтөлбөрт хамрагдсан бүх өрхүүд халамжаас гарах эсвэл бүр гарах ёстой гэсэн үг. Тухайлбал, хөгжлийн бэрхшээлтэй, бүтэн өнчин, ахмад настан, бие физиологийн болон сэтгэцийн эрүүл мэндийн архаг хууч өвчтэй иргэд зэрэг нийгмийн халамжийн үйлчилгээг үргэлжлүүлэн авах шаардлагатай хүмүүс ч “сайн-өрх” болж халамжаас гарах хэрэгтэй болно гэсэн үг³⁸. Орлого бий болгох чадвар нь ядуурал-зорилтот халамжийн хөтөлбөрт бүх ядуу өрхүүдийг оруулах боломжгүй. Ихэнх ядуу өрхүүдэд элбэг олддог албан бус ажил нь бага цалин хөлстэй, эрсдэлтэй, аюултай ажил хөдөлмөр байдаг бөгөөд хэрвээ бүгд биш юмаа гэхэд зарим өрхүүд зохистой амьдрал, наад захын хэрэгцээгээ хангахын тулд халамжийн тусламж дэмжлэг үргэлжлүүлэн авах хэрэгтэй болдог.

4.2 Зөвлөмж

1. **Өрхийн амьжиргааны түвшинг дээшлүүлэх, тэдний зан үйлийг өөрчлөнө гэдэг нь урт хугацааны арга зүйг шаардана.** Өрхийн амьжиргааг сайжруулах, зан үйлийг өөрчлөх нь урт хугацааны оролдлого, үр нөлөөний дүнд бий болох тул өрхүүдтэй урт хугацаанд ажиллах нийгмийн халамжийн хөтөлбөр/үйлчилгээ хэрэгтэй байна. Үүний тулд, үндэсний хөтөлбөрийг цаашид үргэжлүүлэхдээ Монгол Улсын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хуулинд заасан Нийгмийн хөгжлийн зорилтот хөтөлбөр (10 жил)-ийн нэгэн хэсэг болгон хэрэгжүүлэх.
2. **Өрхийг зөв сонгох, тодорхойлохын тулд өрхийн амьжиргааны түвшинг илэрхийлэх үнэлгээ бүхий мэдээллийн санг бий болгох.** Нийгмийн ажилтнууд болон Амьжиргааг дэмжих зөвлөл энэхүү мэдээллийн сангийн мэдээлэлд үндэслэн оновчтой төслийг боловсруулах, бусад өрхүүд яагаад хөтөлбөрт сонгогдоогүйг ил тод тодорхой болох. Гэхдээ өрхийг хөтөлбөрт хамруулах талаарх шийдвэрийг аймаг/дүүргийн холбогдох байгууллагуудтай эргэн холбогдож мэдээлж байх.
 - Өрхийн эхний үнэлгээ (хөгжлийн гурвалжин)-г энэхүү мэдээллийн санд оруулж, баримтжуулж байх. Ахиц дэвшлийн үнэлгээ болон хэрэгжүүлсэн үйл ажиллагаануудын талаарх мэдээллийг мөн мэдээллийн санд оруулдаг болох.
3. **Бодитой, шүүмжлэлтэйгээр нөөцийн үнэлгээг төгсөлтийн хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд хийх ёстой.** Энэ нь үйл ажиллагааны болон хөтөлбөрийн хангалттай төсөвтэй байхыг шаардахын зэрэгцээ хангалттай хүний нөөц, ур чадварыг мөн шаардана.
 - Засгийн газар хөтөлбөрийн санхүүжилт, дэмжлэгийг олон талт хэлбэрээр бий болгох: янз бүрийн түвшинд олон эх үүсвэрээс бий болгох;
 - ЗӨХХҮХ-ийг хэрэгжүүлэх явцад нийгмийн ажилтнууд зорилтот өрхтэй ажиллах сайн туршлагатай болсон. Энэхүү туршлага нь ирээдүйд ижил төстэй хөтөлбөр хэрэгжүүлэхэд хэрэглэгдэнэ.
4. **Хөтөлбөрийн зорилго, ухуулга сурталчилгааны тухай харилцаа холбоо чухал.** Өрх, хүн бүр хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлэх үеэс мэдлэгтэй байж, ойлгох, дэмжих. Хөтөлбөрт

³⁸ <https://europa.eu/capacity4dev/articles/graduation-social-protection-what-it-means-how-it-works>

дэмжлэг үзүүлэх, хөтөлбөрийн үр дүнг дэмжих, хөтөлбөрийн манлайллыг бий болгох, нийгмийн маркетингийн стратегид хөтөлбөрийг тусгах.

5. **Хөтөлбөрийн загвар, хэрэгжилтийн хамтын аргачлал чухал.** Шаардлагатай бүх хүмүүсийг оролцуулах, хамруулах: оролцох боломжийг бий болгох, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, нөөцийг хуваалцах, ил тод харилцах, нийгмийн ажилтан, олон нийт, байгууллагуудыг чадавхжуулах, сургалт, манлайллын боломжийг бүрдүүлэх.
6. **Төгсөлтийн аргачлалыг, ялангуяа, түүний тулгуур багана, шалгуур, үр өгөөжийг сайтар судалж, үндэсний хөтөлбөрийн арга зүйтэй уялдуулах.** Өрхийн тусгайлсан хэрэгцээ бүрийг анхааран, тэдгээрт хариу арга хэмжээ, үйлдэл үзүүлэхэд чиглэсэн системтэй, зохистой үйл ажиллагааг хөтөлбөрийн хүрээнд төлөвлөх, бий болгох.

Ашигласан материал

Дэлхийн зөн, СИКА ХХК, 2020. “Төгсөлтийн аргачлал-600 судалгааны эцсийн үнэлгээ”, Улаанбаатар

Монгол Улсын Засгийн газар. 2016. “Зорилтот өрхийн хөгжил, хамгаалалыг сайжруулах үндэсний хөтөлбөр”

ҮСХ. 2019. “Өрхийн нийгэм-эдийн засгийн судалгаа” Үндсэн тайлан.

ХХҮЕГ. 2014. “Өрхийн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан”

ХХҮЕГ. 2016. “Зорилтот өрхийн хөгжил, хамгаалалыг сайжруулах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн жилийн тайлан”

_____ 2017. “Зорилтот өрхийн хөгжил, хамгаалалыг сайжруулах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн жилийн тайлан”

_____ 2018. “Зорилтот өрхийн хөгжил, хамгаалалыг сайжруулах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн жилийн тайлан”

_____ 2019. “Зорилтот өрхийн хөгжил, хамгаалалыг сайжруулах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн жилийн тайлан”

Хөдөлмөр, халамжийн хэлтэс, Сонгинохайрхан дүүрэг, Улаанбаатар. 2019. “Жилийн ажлын тайлан 2017-2019”

<https://1212.mn>

<https://onlinelibrary.wiley.com/doi/10.1111/1759-5436.12124>

<https://socialprotection.org/discover/blog/integrating-graduation-cash-transfer-programs-experiences-latin-america>

<https://europa.eu/capacity4dev/articles/graduation-social-protection-what-it-means-how-it-works>

	Албан тушаал
1	ХНХЯ-ны Нийгмийн халамжийн хэлтсийн дарга
2	ХНХЯ-ны Хүн амын хөгжлийн хэлтсийн дарга
3	ХНХЯ-ны Бодлого, төлөвлөлтийн газрын Нийгмийн хамгааллын хэлтсийн ахлах
4	ХХҮЕГ-ын Нийгмийн халамжийн хэлтсийн дарга
5	ХХҮЕГ-ын ЗӨХХСҮХ хариуцсан мэргэжилтэн
6	Сонгинохайрхан дүүргийн Хөдөлмөр, халамжийн газрын дарга
7	Сонгинохайрхан дүүргийн Хөдөлмөр, халамжийн газрын ЗӨХХСҮХ хариуцсан мэргэжилтэн
8	Сонгинохайрхан дүүргийн Хөдөлмөр, халамжийн газрын ХШҮ-ний мэргэжилтэн
9	Сонгинохайрхан дүүргийн 8-р хорооны нийгмийн халамжийн ажилтан
10	Сонгинохайрхан дүүргийн 24-р хорооны нийгмийн халамжийн ажилтан
11	Сонгинохайрхан дүүргийн 6-р хорооны нийгмийн халамжийн ажилтан
12	Сонгинохайрхан дүүргийн 3-р хорооны нийгмийн халамжийн ажилтан
14	Сонгинохайрхан дүүргийн Амьжиргааг дэмжих зөвлөлийн гишүүн
15	Сонгинохайрхан дүүргийн 3-р хорооны хамтарсан багийн гишүүн
16	Сонгинохайрхан дүүргийн 6-р хорооны хамтарсан багийн гишүүн
17	Сонгинохайрхан дүүргийн 8-р хорооны хамтарсан багийн гишүүн
18	Сонгинохайрхан дүүргийн 8-р хорооны өрх
19	Сонгинохайрхан дүүргийн 8-р хорооны өрх
20	Сонгинохайрхан дүүргийн 8-р хорооны өрх
21	Сонгинохайрхан дүүргийн 24-р хорооны өрх
22	Сонгинохайрхан дүүргийн 24-р хорооны өрх
23	Сонгинохайрхан дүүргийн 6-р хорооны өрх
24	Сонгинохайрхан дүүргийн 6-р хорооны өрх
25	Сонгинохайрхан дүүргийн 3-р хорооны өрх
26	Сонгинохайрхан дүүргийн 3-р хорооны өрх
27	Налайх дүүргийн Хөдөлмөр, халамжийн газрын дарга
28	Налайх дүүргийн Хөдөлмөр, халамжийн газрын ЗӨХХСҮХ хариуцсан мэргэжилтэн
29	Налайх дүүргийн засаг дарга
30	Налайх дүүргийн хорооны засаг дарга
31	Налайх дүүргийн Хөдөлмөр, халамжийн газрын ЗӨХХСҮХ хариуцсан мэргэжилтэн
32	Налайх дүүрэг, хорооны нийгмийн ажилтан
33	Налайх дүүрэг, хорооны нийгмийн халамжийн ажилтан
34	Налайх дүүргийн Хамтарсан багийн гишүүн
35	Налайх дүүргийн ГБХЗХГ-ын мэргэжилтэн
36	Налайх дүүрэг, өрхийн эмч
37	Налайх дүүргийн өрх
38	Налайх дүүргийн өрх
39	Налайх дүүргийн өрх
40	Налайх дүүргийн өрх

Албан тушаал	
41	Налайх дүүргийн өрх
42	Налайх дүүргийн өрх
43	Налайх дүүргийн өрх
44	Налайх дүүргийн өрх
45	Налайх дүүргийн өрх
46	Хөвсгөл аймгийн Хөдөлмөр, халамжийн газрын дарга
47	Хөвсгөл аймгийн Хөдөлмөр, халамжийн газрын хэлтсийн дарга
48	Хөвсгөл аймгийн Хөдөлмөр, халамжийн газрын мэргэжилтэн
49	Хөвсгөл аймгийн Мөрөн сумын багийн дарга
50	Хөвсгөл аймгийн Хөдөлмөр, халамжийн газрын ХШҮ-ний мэргэжилтэн
51	Хөвсгөл аймгийн Хөдөлмөр, халамжийн газрын ЗӨХХСҮХ хариуцсан мэргэжилтэн
52	Хөвсгөл аймгийн Мөрөн сумын Амьжиргааг дэмжих зөвлөлийн дарга
53	Хөвсгөл аймгийн Мөрөн сумын Амьжиргааг дэмжих зөвлөлийн гишүүн
55	Хөвсгөл аймгийн Мөрөн сумын хамтарсан багийн гишүүн
56	Хөвсгөл аймгийн Мөрөн сумын хамтарсан багийн гишүүн
57	Хөвсгөл аймгийн Мөрөн сумын өрх
58	Хөвсгөл аймгийн Мөрөн сумын өрх
59	Хөвсгөл аймгийн Мөрөн сумын өрх
60	Хөвсгөл аймгийн Мөрөн сумын өрх
61	Хөвсгөл аймгийн Мөрөн сумын өрх
62	Хөвсгөл аймгийн Мөрөн сумын өрх
63	Хөвсгөл аймгийн Хатгал тосгоны захирагч
64	Хөвсгөл аймгийн Хатгал сумын нийгмийн ажилтан
65	Хөвсгөл аймгийн Хатгал сумын хамтарсан багийн гишүүн
66	Хөвсгөл аймгийн Хатгал сумын хамтарсан багийн гишүүн
67	Хөвсгөл аймгийн Хатгал сумын өрх
68	Хөвсгөл аймгийн Хатгал сумын өрх
69	Хөвсгөл аймгийн Хатгал сумын өрх
70	Хөвсгөл аймгийн Хатгал сумын өрх

Хавсралт Б

Нэмэлт мэдээлэл

Аймаг, дүүргийн хэмжээнд хөтөлбөрт хамруулах өрхийн тооны доод хязгаар

Аймаг, дүүрэг	Хөтөлбөрийн хугацаанд хамруулах өрхийн тоо /2016-2020 онд/	Нэг жилд хамруулах зорилтот өрхийн тоо
Архангай	2050	513
Баян-Өлгий	1764	441
Баянхонгор	1873	468
Булган	1404	351
Говь-Алтай	1235	309
Говьсүмбэр	324	81
Дархан-Уул	1878	469
Дорноговь	1303	326
Дорнод	2128	532
Дундговь	898	225
Завхан	1597	399
Орхон	1993	498
Өвөрхангай	2514	629
Өмнөговь	1345	336
Сүхбаатар	1597	399
Сэлэнгэ	2023	506
Төв	1892	473
Увс	1626	406
Ховд	1655	414
Хөвсгөл	2845	711
Хэнтий	2161	540
Аймгийн дүн	36104	9026
Багануур	418	105
Багахангай	54	13
Баянгол	2858	714
Баянзүрх	4480	1120
Налайх	491	123
Сонгинохайрхан	4042	1010
Сүхбаатар	1788	447
Хан-Уул	2060	515
Чингэлтэй	2041	510
Нийслэлийн дүн	18231	4558
Улсын дүн	54335	13584

Эх үүсвэр: Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2016 оны 02 сарын 22-ны өдрийн А/26 дугаар тушаалын 9 дүгээр хавсралт